

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
10 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7 - 68
1. Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	7 - 15
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	16 - 49
3. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	49 - 68

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 04-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны
ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Алтанхуяг, Д.Батлут, Б.Батцэцэг, Б.Батбаатар, Э.Болормаа, С.Ганбаатар, Х.Жангабыл, С.Зулпхар, М.Мандхай, Ц.Мөнхбат, Р.Сэддорж, Ч.Ундрал, Д.Үүрийнтуяа, Да.Цогтбаатар;

Чөлөөтэй: Х.Баттулга, Г.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Н.Наранбаатар, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Б.Бейсен, А.Ганбаатар, Э.Одбаяр, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, О.Амгаланбаатар, Т.Аубакир, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, С.Лүндэг, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн, Н.Учрал;

Хоцорсон: Н.Алтаншагай – 15 минут, С.Амарсайхан – 15 минут, Э.Батицугар – 03 минут, Х.Булгантуяа – 51 минут, Л.Гантөмөр – 01 минут, Х.Ганхуяг – 06 минут, Т.Доржханд – 55 минут, Б.Жаргалан – 07 минут, Ц.Мөнхтуяа – 06 минут, З.Мэндсайхан – 1 цаг 28 минут, Б.Найдалаа – 03 минут, С.Одонтуяа – 08 минут, Г.Уянгахишиг – 01 минут, Д.Цогтбаатар – 06 минут, Б.Чойжилсүрэн – 06 минут, Л.Энх-Амгалан – 01 минут, Ж.Энхбаяр – 05 минут, Р.Эрдэнэбүрэн – 08 минут.

Нэг.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дарга П.Очбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос гаргасан Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын санал дэмжигдсэн тул хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар, Н.Ууганбаатар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Баярхүү, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, мөн яамны Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 10 цаг 55 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Д.Пүрэвдаваа, Ж.Баярмаа, Б.Түвшин, П.Ганзориг, С.Эрдэнэбат, Э.Батшугар, Ц.Мөнхтуяа, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 12 цаг 08 минутаас хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	26
Бүгд:	81

67.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар, Н.Ууганбаатар, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх И.Мөнхжаргал, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн

санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, төсвийн төслийн талаарх Үндэсний аудитын газраас гаргасан дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгээс Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт ажлын 5 өдрийн завсарлага өгөв.

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 55 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 89 гишүүн ирж, 70.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 03 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

66 гишүүн ирснээр 52.4 хувьтай ирц хүрсэн байна.

2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Хоёрдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Гуравдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орё.

Нэг. Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их

Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна.

Индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалт, хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн талаарх дүгнэлт.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг 2024 оны 6 сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн чуулганаар хэлэлцэн хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж шийдвэрлэж “Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоолыг баталсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан дээрх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5-д заасан журмын дагуу боловсруулж, Байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед

-Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг “түр саатуулах шийдвэр, түүний үндэслэл шалтгааныг тухайн этгээдэд танилцуулж” гэсэн нь түр саатуулах байранд шууд хийх агуулга багтаж байгаа эсэх, мөн шийдвэрийг танилцуулах явцад оргон зайлсан тохиолдолд түр саатуулж эхлэх хугацааг хэрхэн тооцох талаар;

-Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган

шийдвэрлэх тухай хуулиар хүнийг баривчлах, саатуулах асуудлыг зохицуулсан байхад Цагдаагийн албаны тухай хуулиар түр саатуулах хугацааг тооцох асуудлыг зохицуулж байгаа нь зөв эсэх талаар;

-Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг түр саатуулах хугацааг тодорхой болгох үүднээс чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан цагаас эхлэн тооцохоор заах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан

-Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг түр саатуулах шийдвэр, түүний үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд танилцуулснаар түр саатуулах хугацааг тоолж эхлэх бус харин чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж, саатуулсан үеэс эхлэн хугацааг тооцож эхлэх нь зүйтэй талаар;

-Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин олон улсын практикт хүний эрхэд ямар нэгэн хязгаарлалт тогтоож байгаа бол хуульчилсан нэг стандартаар халдахыг зөвшөөрдөг бөгөөд харин манай улсад аливаа нэг байгууллагын даргын баталсан журмаар хүний эрхийг хязгаарлах асуудал гарч байгааг анхаарч үзэх, Засгийн газраас Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төслийг яаралтай өргөн мэдүүлэх нь зүйтэй гэсэн талаар;

-Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хүний эрхийг хязгаарлаж эхлэх цагийг нарийн тооцож, суурин газар, хөдөө орон нутагт хэрхэх талаар ялгаа заагийг зөв гаргах;

-Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалд хүний эрхийг хязгаарлах талаарх зохицуулалтыг өөр өөр хуулиар зохицуулж байгаа нь хүний эрхийг зөрчиж байгаа тул цаашид анхаарах;

-Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг эрх, үүргийг тайлбарласнаар түр саатуулах хугацааг тоолж эхлэх шаардлагагүй бөгөөд энэ нь зөвхөн процесст тавигдах шаардлагын нэг болох талаар, мөн тухайн хүн өөрийн дураар зорчих боломжгүй болсон үеэс эхлэн түр саатуулах хугацааг тооцож эхлэх нь зүйтэй талаар;

-Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара хөдөө орон нутаг, байршлаас шалтгаалан тухайн нөхцөл байдлыг харгалзаж түр саатуулах хугацааг уян хатан зохицуулах нь зүйтэй талаар;

-Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хүний эрхийг хязгаарлах асуудлыг байгууллагын хуулиар зохицуулж байгаа нь учир дутагдалтай байгаа талаар;

-Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хүнийг 6 цагаар түр саатуулахдаа түр саатуулах байранд хүргэснээс эхлэн уг 6 цагийг тоолж эхэлж байгаа нь Үндсэн хуулийн зөрчил гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээж авсан.

Иймд хуульд заасан хугацаанд энэхүү зохицуулалтыг хүний эрхийн нөхцөл байдлыг дордуулахгүйгээр яаралтай өөрчилж, түр саатуулах хугацааг тоолж эхлэх мөчийг тодорхой болгох шаардлагатай талаар тус тус санал хэлсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.24-д заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Тамгын газар энэ хуралдаантай өдөр цагтаа ирээгүй Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг тэр даруйд нь хэвлэлд мэдээлж байх үүргийг Улсын Их Хурлын даргын зүгээс өгч байна.

Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдчихоод долоо хоногийн хоёрхон өдөр чуулгантай. Өглөө 10.00 цагт цагтаа

ирж чадахгүй байгаа гишүүдийн асуудлаар тойргийнх нь иргэдэд мэдээллийг байнга өгч байх ёстой гэсэн ийм байр суурийг илэрхийлж байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Нэрсийг оруулахыг хүсэж байна.
/алх цохив/

Дарааллын дагуу
Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууна.

Х.Тэмүүжин: Асуулт гэхээсээ илүүтэйгээр үг байгаа юм.

Үндсэн хуулийн цэц дээр цагдаагийн байгууллагын Цагдаагийн албаны хуульд байгаа нэг заалт дээр цэцээс дүгнэлт гарсан.

Иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлаж байна, хүний эрхийг дордуулсан маягтай хэрэглэж байна гэдэг ийм үндэслэлээр.

Гэхдээ энэ цагдаагийн байгууллагын хууль дээр байгаа учраас л цэц үүнийг авч хэлэлцэж байгаа болохоос биш хуульгүйгээр яг ийм үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд цаана нь бас цөөн биш байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар байна, Авлигатай тэмцэх газар байна, Хил хамгаалах газар байна гэх мэтчилэн. Энэ байгууллагууд.

Тийм учраас Улсын Их Хурал, тэр дундаа Хууль зүйн байнгын хороо

мэргэжлийн байдлаар асуудалд хандаад, ер нь байгууллагын даргын заавар журмаар, эсвэл нэг Ерөнхий прокурорын гаргасан журмаар иргэний үндсэн эрх рүү халддаг халдлагыг одоо зогсоох цаг болсон юм байна.

Монгол Улсын Үндсэн хууль дээр маш тодорхой заасан байгаа. Иргэний эрх, эрх чөлөөг гагцхүү хуульд заасан үндэслэл журмаар хязгаарлана гэж байгаа юм.

Гэтэл Монгол Улсад байгууллагын даргын гаргасан заавар журмаар хязгаарладаг энэ үйл явдал одоо 30 жил оршин тогтнож байна.

Гаалийн байгууллага жишээ нь иргэний өмч хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, битүүмжилж хурааж авах, тэр хүний машин тэрэг болон хүнийг түр саатуулах үйл ажиллагаа явуулахдаа байгууллагынхаа даргын гаргасан журмаар явж байгаа юм. Цагдаагийн байгууллагад л ганцхан ийм хууль байж байгаа.

Тэгэхээр одоо хууль сахиулах үйл ажиллагааны хууль бол үнэхээр хэрэгтэй байна.

Иргэний өмч хөрөнгө, бие, орон байр гэдэг чинь нэг л объект. Үүнийг байгууллага болгон өөрийнхөө өнцгөөр, өөрийнхөө журмаар халдаж ерөөсөө болохгүй. Хуулийн нэг стандарт л байх ёстой.

Тийм учраас Улсын Их Хурлаас тогтоол гаргадаг юм уу, Хууль зүйн байнгын хорооноос ямар нэгэн чиглэл өгөөд Засгийн газарт хууль сахиулах үйл ажиллагааныхаа хуулийг оруулж ир ээ.

Тэр хуулиараа төрийн ямар байгууллага байгаагаас үл шалтгаалаад иргэний өмч хөрөнгө рүү халдаж байгаа бол, орон байр луу нэвтэрч байгаа бол, хувь хүний биеийг өөрийг нь саатуулж байгаа бол нэг стандарт, нэг журмаар халдана.

Одоо та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. Гадаадад очоод хилээр ороод онгоцны буудал дээр буухад гаалийн байцаагч эд зүйлд чинь үзлэг хийж байгаа.

Гэхдээ нэг л зарчим барьж байгаа. Ямар зарчим барьж байгаа гэхээр манайд бол “Police Act” юм уу, эсвэл хууль сахиулах “Law Enforcement Act” гэж ярьдаг хууль сахиулах хуулийг энд барьдаг.

Таны энэ бараанаас, тээшнээс хар тамхи гарч ирэхэд яг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн стандартыг дагаад наадах чинь нотлох баримт болох ёстой.

Бид байгууллагынхаа журмаар, эсвэл өөр тусдаа хуулиар энэ ажиллагааг хийдэггүй гэж хэлж байгаа байхгүй юу.

Гэтэл Монгол Улс бол иргэн рүүгээ зүгээр л хуульгүйгээр халддаг ийм жишиг 30 жил тогтоочихлоо.

Одоо зөвхөн цагдаагийн алба нь энэ хуулийг өөрчлөх тухай биш. Хууль сахиулах ажиллагааныхаа хуулийг гаргаж ирээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага байна уу, Авлигатай тэмцэх газар байна уу, гаалийн байгууллага байна уу, цагдаагийн байгууллага байна уу ялгаагүй нэг хуулиар нэг стандартаар хүний эрх рүү халддаг, хязгаарладаг. Хэрвээ алдаа гарсан бол тэр хуулийнхаа

дагуу бас хэмжигдэж өөрсдөө хариуцлага хүлээдэг энэ тогтолцоо руугаа шилжихгүй бол иргэний эрх бол ямар ч үнэ цэнгүй болчихсон.

Монгол Улсад муйхар хүчирхийлэл, ухаалаг асуултад хариулт хэлж чадахгүй, үндэслэлгүй, хуульгүй ийм дарангуйлал тогтчихоод байна.

Үүнийгээ хэдүүлээ зохистой шийдье. Энэ бол түр зуурын зохицуулалт шүү. Цагдаагийн албаны энэ өөрчлөлт бол ер нь байгууллагын хуулиар процесс шийдэхээ болих цаг болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, гаалийн байгууллага, хил хамгаалах байгууллага гээд дандаа байгууллагад зориулсан хуулиар иргэнийхээ эрхийг хязгаарладаг энэ нэг философио өөрчлөөд процессынх нь хуулиудыг жоохон нарийвчилж, тодорхой болгож, нэг мөр байдлаар шийдэхгүй бол энэ нэг цагдаажсан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асуухаар нэр ирсэн байна. Байхгүй байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асуух нь. Алга байна.

Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна.

М.Нарантуяа-Нара: Сайн байцгаана уу? Өглөөний мэнд хүргэе.

Одоо жагсаал цуглаан хийж байхад үг, үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг шууд ямар нэгэн ийм юу гэдэг билээ, энэ 26.1-д заасан зүйлээр д цагдаагийн албанаас саатуулах тухай

мэдэгдэлгүйгээр шууд ачаад ачаад явчихдаг юм шүү дээ.

Та бүхэн мэдэж байгаа. Дөнгөж сая Оросын ерөнхийлөгч В.Путиний айлчлалтай холбоотой бас зөндөө олон иргэд үг, үзэл санаагаа илэрхийлэхээр энэ талбайн ойр орчимд явж байгаад мал адгуус шиг байнга л ачигдаад явагддаг.

Тэгээд энэ дээр чинь энэ зүйл нь жишээлбэл нарийвчлан тусгаж өгмөөр юм шиг санагдаад байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл хэрвээ тэр иргэний эрхэнд тийм ээ, төр халдсан л байгаа бол тэр анх хэн тэр машинд чихсэн бэ, тэр хүн дараа нь ямар үндэслэлээр ингэх эрхтэй байсан бэ гэдэг дээрээ бас хариуцлага тооцдог баймаар байгаа юм.

Тэгэхгүй дураараа ачаад л, дураараа саатуулаад л, тэгээд буцаагаад тавьж байгаа нь бараг шагнал урамшуулал нь болж байгаа юм шиг яваад байдаг.

Тэгэхээр хэн ч байсан үг, үзэл бодлоо илэрхийлэх эрх нь Үндсэн хуулиар олгогдчихсон байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд өөрсдийнхөө үг, үзэл бодлыг илэрхийлээд явж байгаа иргэдийг шууд үйл ажиллагааны юунд халдлаа гэдэг ч юм уу, ямар нэгэн байдлаар шууд ачаад байдаг энэ байдалд цагдаагийн байгууллага өөрөө ямар хариуцлага хүлээдэг вэ? Ямар дүрэм журмаар, ямар юугаар?

Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг энэ дээр тусгаж өгмөөр байгаа юм. Тэгээд энэ 26.2-той холбоотойгоор миний бодлоор хөдөө орон нутагтаа энэ цаг хугацааг нь уян хатан тавьж өгөөд, төв суурин, тэр

интернэтийн асуудал, тэр олон юм ярьдаг юм билээ.

Тэгэхээр түүндээ нийцсэн хэсэгчилсэн сегментчилсэн ийм боломжтой зүйлийг бүр нарийвчлан заавал яасан юм бэ гэж санал оруулмаар байна.

Д.Амарбаясгалан: Асуултад Д.Цогтбаатар дарга хариулах уу? Тэгье. Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар гишүүн хариулья.

Д.Цогтбаатар: Бид Цагдаагийн тухай хуулийн 26.1-ийг ярьж байгаа юм.

Тэгээд энэ өөрөө тусгай заалт байхгүй юу. Юу гэхээр гэмт хэрэг зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн нь очоод цагдаа саатуулах арга хэмжээ авах гэж байгаа тухай. Яг л энэ тухай л асуудал.

Түүнээс цагдаагийн үйл ажиллагаа бол өөрөө хэв журмыг сахиулах үйл ажиллагаа чинь бол хамаагүй өргөн байж байгаа шүү дээ.

Зам дээр замын цагдаа цагдаа хүн зогсоож байгаад одоо цуваа өнгөрөхөд зогсоогоод хөдөлгөөнийг нь саатуулчхаж л байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнд ерөөсөө хамаарахгүй. Тэрийг зохицуулсан юу биш.

Тэгэхээр энэ дээр бол яах аргагүй тэр харин сая М.Нарантуяа-Нара гишүүн хэлж байна. Тэр хөдөө орон нутагт бол нээрээ энэ чинь 6 цаг нь хүрэхгүй байх тохиолдол.

Ялангуяа тэр нинжа, хууль бус уул уурхай хийж байгаа хүмүүс, эд нарын нэр

хаягийг тогтоох, хөдөөгөөс төв газар луу орж ирж мэдээлэлтэй газраа шалгахад цаг ороод 6 нь өнгөрөх гээд байгаа юм билээ.

Тэгэхээр би энэ дээр Байнгын хорооноос ямар чиглэл өгч байгаа вэ гэхээр энэ хуулийг хуулиар өгөгдсөн хугацаандаа.

Энэ чинь 14 хоногт байгаа байх. Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргасны дагуу чуулган эхлээд л бид тэр хуулийн хугацаандаа хэлэлцээд шийдэж байгаа юм.

Харин цагдаагийнханд үүнтэй холбогдоод тэнд гарч байгаа хүндрэлтэй энэ асуудлаараа харин хуулийн төслөө боловсруулаад ороод ир гэдэг тэр чиглэлийг их тодорхой өгч байгаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Нямтайширын Номтойбаяр гишүүн. Алга байна.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Хууль батлагдсаны дараа цагдаагийн байгууллага хууль хэрэглэхэд яг одоо өнөөдрийн бид нарын хэлэлцүүлгээр хэлж байгаа саналууд, мөн үүнийг тайлбарлаж хэрэглэх дэлгэрэнгүй тайлбар хэрэглээндээ ороход бид нарын асуултууд их чухал байдаг.

Тэгэхээр энэ дээр тодорхой зарим нэг зүйлийг тодруулаад асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, процессын хууль болоод буюу Эрүүгийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудаар хүнийг “саатуулах”, “баривчлах”

ажиллагааг хуулиар зохицуулаад байхад дахиад Цагдаагийн байгууллагын тухай хуулиар “түр саатуулах” юм. Нөгөө “албадан саатуулах”-аас гадна зөвхөн түр саатуулахыг нь энэ хуулиар зохицуулаад байгаа нь хэр оновчтой вэ? Нэг асуулт.

Хоёрдугаарт нь, 22.2-т заасныг нэн даруй танилцуулах шаардлагатай.

Бидний гол санаа зовоод байгаа юм тэр шүү дээ. Эрх, үүргийг нь танилцуулахгүй өрөөнийхөө гадаа суулгаад л байдаг, суулгаад л байдаг, 2, 3 цагийн дараа таныг ер нь “түр саатуулах” гэж байна гэдэг ийм байдлаар цагдаагийн байгууллага ажиллах вий гэдгээс болгоомжилж, хүний эрхийг зөрчих вий гэдгээр болгоомжилж байгаа учраас энэ 22.2-ыг зориуд эшилж энэ заалт дээр оруулж байгаа.

Тэгэхээр энэ дээр “нэн даруй” гэдэг зохицуулалтыг заавал оруулж ирэх хэрэгтэй байна.

Тэгээд хамгийн сүүлд нь энэ жагсаал цуглааны үед ялангуяа 26.2-ыг маш их хэрэглэж хүмүүсийг саатуулдаг.

Энэ бол Эрүүгийн процессын хуульд хамаарахгүй, Зөрчлийн процессын хуульд хамаарахгүй. Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасныхаа дагуу бид нар түр саатуулах, шалгах хэрэгтэй учраас гэдгээр энэ 26.2-ыг маш их хэрэглэдэг гэдгийг бид санах хэрэгтэй.

Тэгээд хамгийн сүүлд нь энэ цагдаагийн байгууллагаас өгсөн тоо байгаа. 2023 онд яг энэ заалтыг хэрэглэж 99 хүнийг түр саатуулсан байгаа юм.

Харин энэ онд 9 гэж байгаа юм.

Тэгэхээр энэ тоо юу нотлоод байна вэ гэвэл ер нь яваандаа Зөрчлийн хууль, Эрүүгийн процессын хуулиараа л энэ асуудлыг шийдэх болохоос биш ер нь цагдаагийн байгууллагын хуулийг хэрэглээнээс ер нь хасагдаж байгаа юм биш үү гэдэг зүйлийг нотлоод байгаа юм болов уу, энэ тоо бас тийм зүйлийг илэрхийлж байгаа болов уу гэж бодож байна. Энэ дээр асуулт.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Д.Цогтбаатар гишүүний микрофон.

Д.Цогтбаатар: Х.Баасанжаргал гишүүний саяын ярьж байгаа, Х.Тэмүүжин гишүүний бас хэлж байгаа саналтай дүйцэж байна л даа.

Тэгэхээр ер нь үүнийг Хууль зүйн байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж байгаа ч юм уу яаж рационализаци хийх вэ гэдгээ ярих нь зөв байх.

Тэгэхээр энэ дээр ямар ч гэсэн эргээд нарийвчлаад судлахгүй бол болохгүй нь гэдэг энэ дээр бол би санал нэгдэж байна.

Түр саатуулах нь цагдаагийн хуульд л байж байгаа нь энэ. Өнөөдөр бид нарын хувьд яг цагдаагийн хууль Үндсэн хуулийн цэц дээр хэлэлцэгдээд ороод ирчихсэн байгаа болохоор үүнийг нь бид янзалж өгөхгүй үлдээчих юм бол хүний эрхийн чинь нөхцөл байдал бүр хуульгүй. Одоо 6 цаг биш 10 цаг ч барьчихсан байхад энэ дээр зохицуулалт байхгүй болчхож байгаа юм.

Тэгэхээр үүнийг нь бид зохицуулж өгөхгүй бол болохгүй болчхоод байгаа.

Үүнийг нь тэгээд сайжруулж өгөх зайлшгүй шаардлагатай.

Харин энэ 26.2-ыг жагсаал цуглааны үед цагдаа хэрэглэж байна гэвэл энэ өөрөө асуудал.

Яагаад гэвэл ахиад энэ 26.1, энэ 26 дугаар зүйл чинь өөрөө тодорхой хэрэг байхыг шаардаж байгаа юм. Тэр хэрэг нээгдчихсэн.

Түүгээр шалгагдаж байгаа хүн сэрдэгдээд энэ хүн байж магадгүй, энэ машин байж магадгүй гээд зогсоож байгаа.

Тэгээд тэр зогсоож байгаа үйлдэл нь би зогсоогоод миний энэ тодруулга хийхэд 6 цаг шаардагдана гэдгээ ухамсрын хувьд ойлгочихсоноор зохиохыг хэлээд байгаа байхгүй юу.

Түүнээс зүгээр хэв журам сахиулж явж байгаад авгай, нөхөр хоёр зодолдож байхад нөхрийг нь чи наад буландаа зогсож бай гэхэд 6 цаг тоологдож эхлэх тухай асуудал ерөөсөө байхгүй. Үүгээр зохицуулагдаагүй байхгүй юу.

Одоо замын цагдаа нөгөө цуваа Вьетнамын Ерөнхийлөгч явахад хөдөлгөөнийг нь хязгаарлачхаж байна шүү дээ.

Тэгэнгүүт 6 цаг тоологдож эхэлнэ гэдэг ойлголт ерөөсөө байхгүй. Энэ өөр зохицуулалт байхгүй юу.

Тэгэхээр үүнтэй андуурч болохгүй. Яг өөрийн чинь хэлж байгаагаар үүнийг та асууж байгаа нь их чухал.

Нэг зүйлийг хэлмээр байна. Барьж эхэлж байгаа бол тэр “Miranda Law” эхэлж үйлчилнэ шүү. 26.2-ийг хэрэглэж байгаа бол эхэлж заавал тэр эрх, үүргийг нь сануулж байж саатуулах үйл ажиллагаандаа орно шүү гэдгийгээ аль аль талдаа ойлгох ёстой.

Хуулийг дараа нь шүүх тайлбарлахдаа хууль тогтоогчид юуг санаж энэ текстийг боловсруулсан бэ гэдгийг тайлбарлахдаа үүнийг ашиглах ёстой. Үүрэгтэй. Яагаад гэвэл хууль юу хүсэж хийснийг бид л өөрсдөө шийднэ.

Тэгэхээр бид яг ингэж хүсэж энэ томъёололыг гаргасан гэсэн үг. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Үг байхгүй. Санал хураалт. /алх цохив/

Хонх нь дуугарахгүй байна. Санал хураалтыг хүчингүй болгоё.

Энэ Их Хурлын системтэй холбоотойгоор аудит хийх, хянан шалгах ажлын хэсгийг Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржоор ахлуулсан. Бүх намын Улсын Их Хурлын гишүүдийн оролцоог хангасан байдлаар ажлын хэсэг байгуулсан байгаа.

Энэ системтэй холбоотой, системийн хэвийн ажиллах нөхцөлийг хангахтай холбоотой ажлын хэсэг ер нь

ойрын үед бас ажиллаж энэ системд ер нь аудит хийх шаардлага нэгэнт үүссэн гэж үзэж байгаа.

Мэдээж одоо энэ санал хураалтын процесс олон үйлдэлд давхардаад хийхээр гацаж байгаа байдал зэргийг аудит хийхгүй бол болохгүй.

Бас нэлээдгүй үнэ өртөгтэй хийгдсэн систем юм билээ. Тэгээд олон улсын түвшинд уг нь шалгарчихсан систем гэж танилцуулагдаж байгаа.

Тэгээд энэ дээр бас нэг аудит хийнэ гэж бодож байна. Санал хураалт явуулъя. /алх цохив/

Бас хонх дуугарсангүй ээ. Санал хураалтыг хүчингүй болгоё.

Төхөөрөмж дээр түр гацаа үүссэн. Ингээд болсон байна. Санал хураалт. /алх цохив/

51 гишүүн дэмжсэнээр 60.0 хувиар дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

Хууль зүйн байнгын хороо гишүүдийн хэлж байгаа саналыг тусгаж, эцсийн найруулгадаа оруулж ирэхийг үүрэг болгож байна, чиглэл болгож байна.

Хэлэлцэх асуудал. Хоёр.

**Хоёр. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр танилцуулна.

Индэрт урья.

Л.Гантөмөр: Өнөөдөр 10 сарын эхний долоо хоногийн Баасан гараг.

Монголын багш нарын баярын өдөр байгаа.

Тэгээд Монголынхоо бүх багш нарт баярын мэнд хүргэе. /алга ташив/

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 8 сарын 30-ны өдөр өөрчлөлт орж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусдаг үзүүлэлтүүдээс

→ нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ,

→ нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ

гэсэн хоёр үзүүлэлт хасагдаж, тэдгээрийн оронд

→ нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ,

→ нэгдсэн төсвийн суурь тэнцэл

гэсэн хоёр үзүүлэлт нэмэгдсэн билээ.

Тус хуулийн өөрчлөлттэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Та бүхэнд танилцуулж байна.

Экспорт, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд 2022-2024 онд хэрэгжүүлсэн цогц арга хэмжээний үр дүнд ашигт малтмалын “ам үнээр” бус “хил үнээр” борлуулдаг болсон.

Мөн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоо бүрдэж, ашигт малтмалын гэрээний бүртгэл бүрэн хийгдсэнээр уул уурхай болон ашигт малтмалын тээврийн салбарт ил тод байдал сайжирсан байна.

Эдгээрийн үр дүнд Монгол Улсын эдийн засаг

- ▶ 2022 онд 5 хувиар,
- ▶ 2023 онд 7.4 хувиар,
- ▶ 2024 оны эхний хагаст 5.6 хувиар тус тус өслөө.

Эдийн засагт гарсан эерэг өөрчлөлтүүдийг олон улсын үнэлгээний агентлаг дүгнэж Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В+” болгож сайжрууллаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан экспортыг дэмжсэн бүтээн байгуулалтууд болон “14 мега төсөл”-ийг цаг алдалгүй хэрэгжүүлж, экспортыг төрөлжүүлэн нэмэгдүүлж, эрчим хүчний эрх чөлөөнд хүрснээр цаашид боловсруулах үйлдвэрлэл хөгжих суурь бүрдэх юм.

Шинжлэх ухаан, технологид суурилсан аж үйлдвэрлэл бол макро эдийн засгийн тогтвортой байдлыг урт хугацаанд хадгалах хамгийн чухал хүчин зүйл байна гэдгийг Та бүхэндээ хэлье.

Экспортыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор худалдааны түнш томоохон улс орнуудтай хийж байгаа чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг гүйцээн нийт зах зээлээ тэлэх болно.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хувийн хэвшилд ээлтэй бизнес, хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэх нь гадаад шокт тэсвэртэй, тогтвортой эдийн засгийг бүрдүүлэх хоёр дахь том хүчин зүйл болох юм.

Бид ирэх жилүүдэд хэрэгжих бүтээн байгуулалтын төслүүд, экспортын

хандлага, аялал жуулчлал, хөдөө аж ахуй зэрэг салбаруудын төлөв байдал болон худалдааны түнш улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан эдийн засгийн өсөлтийг

- ▷ 2025 онд 8 хувь,
- ▷ 2026, 2027 онд тус тус 6.5 хувь орчимд байхаар тооцоолж байна.

2025 онд “14 мега төсөл”-ийн хэрэгжилт эдийн засгийн 8 хувийн өсөлтийн 2.2 хувь буюу дөрөвний нэгийг бүрдүүлэхээр харагдаж байна.

- ▶ 2024 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 95 их наяд төгрөгт хүрч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 6800 ам.доллар болно.

Мөн экспорт 19 тэрбум ам.долларт хүрч гадаад валютын нөөц 5.7 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Мөн цар тахал болон Украйнд болж байгаа дайны нөлөөгөөр 2022 онд 16.9 хувь болж өсөөд байсан инфляц

- 2023 оны эцэст 7.9 хувь,
- 2024 оны 8 дугаар сарын байдлаар 6.5 хувь болж буураад байна.

Цаашид валютын нөөцийг зузаатгаж, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой нэмэгдүүлэн төсөв, мөнгөний оновчтой бодлогыг хэрэгжүүлснээр инфляцыг

- 2025 онд 7.5 хувь,
- 2026 онд 5 хувь,
- 2027 онд 4 хувьд хүргэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Та бүхэнд танилцуулж байгаа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны

төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг хангасан болно.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Өглөөний мэнд.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг

хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд томоохон хөгжлийн төслүүдийн барилга, угсралтын ажлыг эхлүүлж, авто зам, эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудын санхүүжилтийг тусгаснаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгийн багтаамжийг тэлэх бодлогыг хэрэгжүүлэх, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн зарим тусгай шаардлагыг өөрчилсөнтэй холбоотойгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед

-Улсын Их Хурлын гишүүн, З.Мэндсайхан макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг тооцсон аргачлалын талаар;

-Улсын Их Хурлын гишүүн, Д.Батбаяр төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтээс зөрүүтэй байгаа шалтгааны талаар;

-Улсын Их Хурлын гишүүн, Д.Пүрэвдаваа гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийг бодитой тооцсон эсэх болон Монгол Улсын ажиллах хүчний тоо 2025 онд буурах эсэх талаар;

-Улсын Их Хурлын гишүүн, Ж.Ганбаатар биржээр борлуулж байгаа нүүрс сүүлийн саруудад буурсан шалтгаан;

-Улсын Их Хурлын гишүүн, С.Эрдэнэбат 2025 онд иргэдийн бодит орлого хэрхэн өсөх болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх боломжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

-Улсын Их Хурлын гишүүн, Б.Заяабал, Д.Пүрэвдаваа, П.Ганзориг, Г.Дамдинням, Б.Мөнхсоёл, Ц.Даваасүрэн нар Улсын Их Хурлын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон Төсвийн төслийн талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тусгайлан хэлэлцдэг байх, тухайн жилийн төсөв болон төсвийн тодотголтой хамт төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүй байхад анхаарах;

-Улсын Их Хурлын гишүүн, Д.Батбаяр, Ж.Ганбаатар нар биржээр борлуулж байгаа нүүрсний хэмжээг бууруулахгүй байхад анхаарч, биржийн үйл ажиллагаанд брокеруудыг оролцуулдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар

хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Зандангийн Баярхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн

санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууна. /алх цохив/

Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа.

Эдийн засаг, хөгжлийн сайдаас нэг асуулт байна л даа.

Өмнөх Эдийн засаг, хөгжлийн сайд мөнгөний бодлогын хувьд бол бас нэлээн тийм хатуу бодлого барьдаг байсан хүн.

Та тэгэхээр мөнгөний бодлогын хувьд өнөөдрийн барьж байгаа бодлогыг ер нь юу гэж үзэж байна аа? Гэхдээ манай энэ Их Хурлын дэг ийм л дээ.

Өөрөө ярьчихаад тайлбарлахгүй бол тодотгол нь нэгхэн минут учраас бодож байгаа зүйлээ хэлэхээс өөр аргагүй болдог юм л даа.

Би бол одоо энэ мөнгөний бодлогыг их хатуу. Үүнээс болоод аж ахуйн нэгжүүд, иргэдийн бизнес ер нь сүүлийн 4 жил их хумигдсан л даа.

Энэ нь өөрөө ард иргэдийн яг хаалга руу эдийн засгийн өсөлт орохгүй байгаа гол шалтгаан.

Эдийн засгийн өсөлт яах вэ улсад бол гайгүй байх шиг байна. Том том төслүүд явах байх. Гэхдээ ард иргэдийн амьдралын чанар, амьжиргааг сайжруулах гол зүйл бол өөрсдөөр нь хөдөлмөрийг нь эрхлүүлэх, өөрсдөөр нь амьдралыг нь сайжруулах энэ зүйл л дээ.

Тэгэхээр Монголбанкны бодлогын хүү одоо би ойлгож байгаагаар 12 хувьтай байгаа байх.

Тэгэхээр зээлийн хүү ойролцоогоор хамгийн багадаа л 15, 16 хувьтай. Түүнээс дээш байгаа.

Үүнийг даваад бизнес эрхлээд, ашиг орлого олоод, олон хүн ажлын байраар хангаад, дээрээс нь улс орондоо татвараа төлөөд, хөгжилд нь оролцоод явах бололцоо маш бага байна л даа. Энэ дээр ямар бодлого барих вэ? Цаашдаа.

Та сая үгэндээ хэллээ л дээ. Төсөв мөнгөний оновчтой бодлого барина гэж.

Үүнийг юу гэж ойлгох юм бэ? Эдийн засаг, хөгжлийн яам энэ дээр маш том байр суурьтай оролцох л ёстой л доо.

Тэгэхээр би Монголбанкны бодлогын хүү буух цаг нь болсон гэж үзэж байгаа.

Саяхан 8 хувьтай, 7 хувьтай байсан. Одоо ингээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Л.Гантөмөр Шадар сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Зарчмын хувьд Ж.Ганбаатар гишүүнтэй санал нэг байна.

Тэгэхдээ мөнгөний бодлогыг Монголбанк гаргахдаа төсвийн зарлагатай их уядаг хоёр том хүчин зүйл байгаа юм.

Нэг нь, валютын нөөц.

Валютын нөөцтэй холбоотой том харгалзаж байгаа зүйл нь импорт.

Мөнгө сулраад мөнгөний нийлүүлэлт идэвхжихээр буюу төсөв тэлэхээр импорт нэмэгддэг. Тэгээд импорт нэмэгдэхээр валютын нөөц хомсддог гэдэг нэг ийм хандлага байгаа юм.

Тэгэхээр жилийн жилд энэ мөнгөний бодлого яагаад хатуу байгаад яваад байсан бэ гэхээр ковидын үед эрс өсгөсөн л дөө. Таны хэлж байгаа 12 хувь руу аваачсан.

Тэгээд 12 хувь руу аваачсан үндсэн шалтгаан бол төсвийн гадуурх ковидын үеийн дэмжлэг гэдэг ийм асар өндөр тоотой мөнгөний нийлүүлэлт явсан.

Ингээд инфляц буураад валютын нөөц 5 тэрбум доллар луу очихоор Монголбанк бодлогын хүүгээ суллаж байгаа. Сулласан. 10 хувь дээр аваачсан. Тэгэхдээ дахиад Монголбанк үүнээс цаашаагаа суллах нөөц их муу байна гэж хэлж байгаа. Яагаад гэвэл өнгөрсөн тодотголын үеэр хэдүүлээ төсвийнхөө зарлагыг тодорхой хэмжээгээр өсгөчихсөн.

Тэгэхээр бид нар төсвийн зарлага энэ зуны одоо тэр ипотекийн зээл, дээр нь малчны тэтгэвэр, тэтгэмж, дээр нь шинэ хоршоо гэдэг мөнгөний урсгалыг бараг 3 их наяд руу авааччихсан. Энэ нөлөөгөөр импорт өнгөрсөн оноосоо бараг 2.5 тэрбум доллароор даваад импорт идэвхжээд явчхаж байгаа юм.

Тийм учраас мөнгөний мөнгө төсвийн бодлогыг зохистой харилцааг барина гэдэг өнөөдрийн энэ зарчим хэрэгжээд явна.

Ер нь ирэх онд мөнгөний бодлогын хүү 10 хувьд байх болов уу гэж харж байгаа. Тэгээд хэрвээ 11 хувь дээр 16 хувийн зээл гарч байгаа бол 10 хувь дээр 15 хувийн зээл гарах болов уу гэсэн нэг ийм зүйл байна.

Нөгөө талдаа бид манай тогтвортой байдлын зөвлөл болоод гишүүдийн гол хэлж байгаа зүйл бол та нар энэ төсвийн орлогоо хэтэрхий өөдрөгөөр төсөөлж байна. Тэр хэмжээгээр зарлага чинь нэмэгдсэн байна гэдэг нэг ийм шүүмжлэл яваад байна шүү дээ. Энэ үед Монголбанк хөдлөхөд их төвөгтэй байх болов уу гэж харж байгаа юм.

Тэгэхээр бид нарын дэвшүүлж байгаа зорилго бол ирэх жил бид импортыг зогсооно гэж хэлэхэд төвөгтэй байна л даа, гишүүн ээ.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн энэ уурхайн бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэлийг идэвхжүүлэх, уул уурхайгаас өөр бидэнд одоо экспортын орлого байхгүй байна.

Тэгэхээр ирэх онд хэрэгжүүлэх хамгийн том зорилт бол экспортоо тууштай хэрэгжүүлээд явна. Ингэж яваад бид нөөцөө 6 тэрбум, 7 тэрбум доллар давуулаад ингээд цаашаага алхах юм бол мэдээж энэ дагаад л бодлогын хүү буурна.

Тэгээд бодлогын хүүгээрээ дамжуулаад бид нарт зүгээр нэг тийм сонголтын алдаа байгаа юм. Жишээлбэл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ж.Ганбаатар гишүүн, тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Тэгээд та “бодлогын хүү” дээр анхаарч ажиллана биз дээ.

Ер нь улс тэгээд мөнгөтэй боллоо, одоо том төслүүд хөдөллөө гэсэн чинь энэ иргэдийн хаалгаар орохгүй бол энэ өөрөө ямар ч үр дүнгүй ажил болдог.

Сайхан замтай боллоо. Сайхан төсөл хэрэгжлээ ч гэсэн иргэдийн амьдралыг сайжруулах гол зүйл бол аж ахуйн нэгж, иргэдийн өөрийнх нь ажил хөдөлмөр хийх тэмүүлэл шүү. Та тэрийг ойлгож байгаа байх гэж бодож байна.

Ерөнхий сайд эртээд хэлж байна лээ л дээ. Энэ том төслүүдээ

хэрэгжүүлэхдээ бид дандаа гаднаас мөнгө оруулна. Дотоодоосоо авахгүй. Энэ зөв байх. Маш зөв байх гэж би бодож байгаа.

Тийм учраас бодлогын хүүд нэг айхтар нөлөөлөөд, хэрвээ энэ зарчмаа баривал Монголын инфляцад нөлөөлөөд байх нь харьцангуй бага болов уу л гэж би бодож байна.

Тийм учраас бодлогын хүү дээр нэлээн тийм анхаарч ажиллахыг танаас хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой хуулийн заалт байгаа юм л даа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тооцож гаргаад түүнийг баримталж тухайн жилийн тооцооллыг гаргах ёстой гээд.

Тэгээд Төсвийн байнгын хорооны хэлэлцүүлэг дээр Засгийн газар энэ тоо баримтуудыг авч хэрэглээгүй гэсэн. Тэгээд энэ зөрчил мөн үү? Хэрхэн яаж уялдаж байгаа юм бэ гэж асуумаар байгаа юм.

Тэгээд 2025 оны эдийн засгийн өсөлтийг 8 хувиар тооцсон байна лээ.

Тэгээд Дэлхийн банк 6.6, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 6.7 гэж тооцсон. Энэ зөрүүг яаж харж байгаа, яаж

тайлбарлаж байгаа юм бэ гэж асуумаар байгаа юм.

Мөн ажиллах хүчний хомсдол. Ялангуяа бизнесийн салбарынхан буюу жижиг дунд бизнес эрхэлж байгаа эдийн засгийн гол цусны эргэлт болдог энэ салбарынхан дунд тулгамдаж байгаа асуудал нь ажиллах хүчний хомсдол байгаа. Энэ мэдээлэл байна уу? 2025 онд энэ ажиллах хүчний хомсдол нэлээн өндөр түвшинд байх болов уу гэдэг таамгийг Монголбанкны зарим тайлан дээрээс харж болохоор байгаа юм.

Тэгэхээр ажиллах хүч нь байхгүй, эдийн засаг нь төсөөлөл нь арай бага байна гэдэг энэ зөрүүтэй ойлголтуудыг яаж Та бүхэн маань өөдрөгөөр хараад байгаа юм бэ гэж асуумаар байна.

Тэгээд хамгийн сүүлд нь. Интернэтээс л харж байгаа юм л даа. Янз янзын нүүрсний үнийн таамгийг харахаар манай бүсийн нүүрсний үнэ тодорхой хувиар 2025, 2026 онд буурна гэсэн чиг хандлагатай байна гэж ойлгосон.

Та бүхэн маань ямар эх үүсвэрээс нүүрсний үнийг өснө гэсэн ийм өөдрөгөөр харж байгаа юм бэ гэдэг үндсэн гурван асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Лувсаньямын Гантөмөр сайд хариулт өгнө.

Л.Гантөмөр: Ер нь газар сайгүй ажиллах хүчний хомсдол гэдэг зүйл яригддаг боллоо.

Тэгээд үүний цаана цалин хөлсний асуудал байгаа болов уу гэж би бодож байгаа.

Л.Энх-Амгалан сайд, Хөдөлмөрийн яам ажиллах хүчнийхээ тооцооллын “big data”-г гаргана гээд зориглоод ажиллаж байна.

Тэгээд хагас жилээр үнэхээр Монгол хүн хэн нь хэн юм, юу хийж чаддаг юм, юу хийгээд байгаа юм, юу хийхгүй байгаа юм гээд томоохон тооцоолол хийх боломж бид нарт гарах байх. Үүнийг Л.Энх-Амгалан сайд тодорхой тайлбарлах нь зөв болов уу гэж бодож байна.

Нүүрсний үнэ айхтар буурах хандлага байхгүй. Яагаад гэвэл Хятадын эдийн засгийг хоёр янзаар хардаг.

Өнгөрсөн хугацаанд нэлээн саарчихлаа, доройтчихлоо, унах юм байна гэдэг. Гадагшаагаа Хятадын мөнгө урсаж байна гэдэг ийм мэдээлэл асар их байсан.

Нөгөө талдаа үнэхээр Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээл унасан байсан.

Үүнтэй уялдуулаад гангийн үйлдвэрлэл саарсан. Саяхан авсан Хятадын төв банк болоод бусад төр засгийнх нь шийдвэрээр өөрийнхөө эдийн засгийн өсөлтийг 5 хувьдаа бид барина. Орон сууцжуулах ажлыг үргэлжлүүлнэ. Ипотекийн зээлийн хүүг бууруулна гэдэг ийм шийдвэр гараад одоо ерөнхий дүгнэлт, олон улсын хөрөнгө оруулагч нар Хятадын зах руу хөрөнгө оруулах хандлага эрс сайжирч байгаа гэдгийг бүгдээрээ харах хэрэгтэй.

Тийм учраас үнэ айхтар буураад, айхтар экспортын алдагдалд хүрнэ гэж бид харахгүй байгаа юм. Нэг.

Нөгөө талаас бидний нийлүүлж байгаа нүүрсний хэмжээг сайжруулах хэрэгтэй. Бид нийлүүлэхийн тулд нүүрсээ олборлох ёстой. Олборлох хүчин чадал маань өсөөд байна гэдгийг бүгдээрээ мэддэг байя, хардаг байя.

Үнэхээр жилээс жилд бидний энэ олборлох, боловсруулах чадвар сайжирч байна. Тээвэрлэх тээврийн салбарын өсөлт 2024 онд их онцгой өндөр гарч байна шүү дээ.

Тэгээд тээвэрлэлт их тогтвортой өсчихлөө. Энэ бол экспортын болгоомжлол багасаж байгаа.

Тогтвортой байдлын зөвлөл маань ажилд ороод удаагүй байна. Их Хурал ч гэсэн, Засгийн газар ч гэсэн Тогтвортой байдлын зөвлөлтэйгөө ажиллаж гүйцэд харилцаанд орох цаг хугацаа, одоо юу гэдэг юм богино хугацаанд харилцаанд амжиж орохгүй байна. Нэг.

Нөгөө талдаа ер нь Тогтвортой байдлын зөвлөл байнга шүүмжлэлтэй хандана. Та хэд манай гишүүд Тогтвортой байдлын зөвлөл өөр үг хэлээд байна, засаг өөр үг хэлээд байна гээд. Энэ өөр үг хэлэх ёстой. Яагаад гэвэл Тогтвортой байдлын зөвлөлийг Та бүхэн Валютын сан л гэж ойлгох хэрэгтэй.

Үнэхээр хараа хяналт тавьдаг байгууллага.

Засгийн газар, Их Хурал бүтээдэг, урагшлуулдаг байгууллага. Дэлхийн банк байнга бага тоогоор өсөлтийг хэлж байдаг шүү.

Монгол Улсын Засгийн газрын төсөөлж байгаа, төлөвлөж байгаагаас

өндөр тоогоор Дэлхийн банк, Валютын сан, Монгол Улс.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Уучлаарай. Д.Пүрэвдаваа гишүүн тодруулга.

Д.Пүрэвдаваа: Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр Засгийн газрын бүрэн эрх гэдэг дээр 10.1.2 дээр аягүй тодорхой заачихсан байгаа.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гээд.

Мөн хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлж төлөвлөлтөө хийнэ гээд заачихсан байгаа.

Тэгэхээр хуульд ингээд заачихсан байхад одоо энэ тоо баримтыг баримтлахгүй байх нь ямар дүрэм журмаар зохицуулагдаад байгаа юм бэ? Энэ зөрчил мөн үү л гэж асуугаад байгаа юм.

Х.Булгантуяа: Л.Гантөмөр дарга нэмж хариулья.

Л.Гантөмөр: Төсвийн шаардлагад өргөн барьж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл бүрэн нийцэж байгаа. Бүрэн нийцэж байгаа.

8 хувийн өсөлттэй байна гэдгийг 2024 оны 5 сард шийдчихсэн байхгүй юу даа. Энэ тоо хөдлөөгүй. Энэ тоог шинэ

Засгийн газар зохиож байгаа тоо биш. Энэ батлагдсан хууль дээр байгаа тоо. Одоо үргэлжлээд явж байгаа гэж Д.Пүрэвдаваа гишүүн ойлгоорой.

Инфляцын хувьд өнгөрсөн батлагдсан тоо нь 1.5 пунктээр дээшээгээ хөдөлж байгаа. Энэ бол өөрөө сэрэмжтэй байгаагийн л дохио. Түүнээс биш бид инфляцаа дахиад бууруулаад ороод ирсэн бол одоо таны шүүмжлэл байх ёстой.

Тэгэхээр одоо энэ тусгай шаардлагуудыг зөрчсөн нэг ч үзүүлэлт төсвийн хүрээний мэдэгдэлд байгаа тоонууд дотор байхгүй шүү гишүүн ээ.

Х.Булгантуяа: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Төсвийн хүрээний мэдэгдэл сая Д.Пүрэвдаваа гишүүний асуултууд зөндөө л гарлаа л даа. Тэгээд 6 сард баталсан байгаа.

6 сард батлахад жишээлбэл төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 31.3 их наяд гэж байгаа. Тийм ээ.

Гэтэл хоёр, гуравхан сарын дараа 35.7 гээд ороод ирсэн. Бүхэл бүтэн 5 их наядаар гэж бид нар яриад байгаа.

Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэлд байгаа энэ тоо одоо энэ төсөв дээр байгаа энэ тоотой зөрөөд байна л даа. Энэ төсөв гэх юм уу, энэ юу гэдэг юм? Төсвийн энэ ном дээр 77 дугаар хуудсан дээр жишээлбэл энэ суурь зарлага нь 32.1 их наяд гэж байгаа юм. Нөгөө бид нарын сая бөөн юм болж Төсвийн тогтвортой байдлын хуульдаа

өөрчлөлт оруулж шаардлага өөрчилсний дагуу энэ ийм болсон байгаа юм. 32.1 гээд. Гэтэл энд болохоор 31.9 гээд.

Тэгэхээр энэ зөрүү чинь одоо ямар учиртай юм бол оо? Ингээд ийм том зөрүү энэ чинь бас л багагүй зөрүү шүү дээ. 1 их наяд гаруй.

Тэгэхээр энэ ингэж зөрж байгаа нь ямар учиртай юм бол оо?

Хоёрдугаарт, дахиад нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д байгаа. Тийм ээ.

2025 оны 01 сарын 01-нээс төсвийн тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 2-оос илүүгүй хувьтай тэнцэнэ гээд.

Гэтэл энэ дээр бас л энэ номын гэх юм уу, хавсралтад энэ чинь арай өөр буюу илүү гарчхаад яваад байх юм. Төсвийн тэнцэл нь 2.3 гээд. Одоо 3 хувиар илүү гарчихсан. Тэгээд энэ чинь бас л багагүй мөнгө. Нөгөө 1.9 их наядын алдагдлаасаа тооцох юм бол бараг 58 тэрбум төгрөг юм уу?

Тэгээд нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь бас нэг хувиар илүү гарчихсан. Ингээд өөд өдөөсөө харсан хоёр хуудсан дээр хоёр өөр тоо ингээд яваад байх юм л даа. Тэгээд энэ зөрүүнүүд ер нь бас ямар учиртай байдаг юм болоо гээд.

Тэгээд энэ яах вэ, одоо нэг ингэж гаргаж ирээд л, Л.Гантөмөр дарга дураараа зохиогоод л хийгээд байгаа юм байхгүй л дээ.

Тэгээд л юм л ярихаар нөгөө хойд талын бор овоохой шиг шахуу юм болох

гээд байна л даа. Л.Гантөмөр дарга руу л дайраад.

Гэтэл угаасаа улсын төсвийн зардал эд нар чинь ерөөсөө бүхэлдээ л жил болгон бүр асар ихээр нэмэгдээд явж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдлээ ч гэсэн. Жишээлбэл, 2022 онд улсын төсвийн нийт зардал 18.2 байсан. Гэтэл 2023 онд 22.5, 2024 оронд бүр 30.5 гээд бүр 8 их наядаар нэмээд яваад байгаа. Тэртээ тэргүй энэ өмнөх он жилүүдэд ч гэсэн ингэж явж байсан.

Тэгээд энэ удаад яах вэ 5 их наядаар нэмэгдээд ороод ирж байна л даа.

Тэгэхээр энэ баримт бичгүүдэд байгаа зөрүүтэй тоонууд чинь ямар учиртай юм бол? Сая Дэлхийн банк Монголын эдийн засгийн өсөлтийг арай багаар харж байгааг ярьсан.

Тэгэхээр магадгүй эдийн засгийн өсөлт дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт бага болоод ирэх юм бол бидний төсвийн хүрээний мэдэгдэлд заасан энэ зүйлүүд чинь өөрчлөгдөөд зөрөөд эхлэх юм биш үү гэсэн тийм аяс харагдаад байна.

Тэгээд л дандаа л ерөөсөө мөчлөг сөрсөн дагасан гээд л эдийн засагчид байнга ярьдаг. Тийм ээ. Үүнийг ерөөсөө нэг өөрчлөхгүй юм уу?

Мөнгө их орж байгаа үедээ жаахан хадгалах гэдэг юм уу тийм юмаа хийхгүй юм уу? Байгаагийнхаа хэрээр үрж хаяад дээрээс нь ингээд зээл аваад яваад байх юм.

Тэгээд дээрээс нь уг нь энэ бүх хуулиудад чинь төсвийн хүрээний мэдэгдэлдээ нийцүүлж төсвөө

боловсруулна батална гээд байгаа шүү дээ. Гэтэл бараг эсрэгээрээ төсвөө боловсруулчхаад тэгээд тэр төсвийнхөө дагуу ямар зээл авах яах ийхээ ингэж тусгачхаад тэрнийхээ дагуу бараг энэ төсвийн хүрээний.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ж.Баярмаа гишүүн их нарийн сайн уншиж асуултууд асууж байна. Л.Гантөмөр сайд хариулах уу? Л.Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Ер нь төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд, өргөн барьсан төсвийг батлахдаа хүрээнийхээ мэдэгдэл дээр байгаа тоогоороо батлах ёстой.

Тэгэхээр тийм хэлэлцүүлгийн шат дараатай учраас ингэж батлагдана.

Ер нь тооны зөрүү байхгүй гэж би хувьдаа харж байна. Үнэхээр байх юм бол тэрийгээ засаад батлах нь бид нарын үүрэг.

Ер нь ийм. Яах вэ бид нар ингээд хөгжлийн төлөө алхаад байгаа юм.

Магадгүй 10 мянган долларын улстай болно гээд ингээд нэг зоригтой алхья гээд алхаж байгаа. Түүнээс биш Засгийн газар хямгаддаг, Их Хурал бол тэлдэг ийм л уламжлалтай шүү дээ.

Сангийн яам бол хямгаддаг. Их Хурлын гишүүд бол мөнгө тавь гэж шахдаг. Ард түмэн шаардаж байна гээд.

Жоохон хөгжье гээд явахаар байрлал нь ингээд солигдчихоод байгаа юм. Гишүүд Сангийн яамны дүрд ороод, Валютын сангийн дүрд ороод.

Бид болохоор гишүүдийн дүрд ороод ингээд улсаа хөгжүүлье л дээ, ард түмэн ядуу байна гэдэг ийм өөр хандлага руу орчхоод байна л даа.

Тийм учраас гишүүд маань яг улс орныхоо хөгжлийг юу бодож, улс орон маань 4 жилийн дараа ямар хөгжилд очих.

Өнөөдөр Ж.Баярмаа гишүүний хэлж байгаатай санал нэг байна. Төсөв тэлж байгаа. Урсгал зардал үнэхээр тэлчихсэн.

Тийм учраас зардлын реформыг хэдүүлээ 2025 онд тал талаасаа ажлын хэсэг гаргаад ажиллая гэдэг ийм л санал санаачилгатай байгаа.

Бид 8 сарын 30-нд байхад тодотголоо баталсан. 9 сарын 01-нд төсвөө өргөн барих ёстой. Өнгөрсөн зун ийм хууль хийчихсэн.

Уг нь 10 сарын 01-нд төсөв өргөн барьдаг байлаа л даа. Хэрвээ 10 сарын 01-нд төсөв өргөн барьж байсан бол бид нар энэ суурь зардал дээрээ тодорхой шийдлүүд гаргахын төлөө ажиллах тийм цаг хугацаа Их Хуралд болоод Засгийн газарт байх байсан болов уу гэж би харж байгаа юм.

Тэгэхдээ бид энэ урсгал зардал өөрөө буруу байна гэж хэлж байгаа хэрэг биш шүү. Тэлж байгаа явдал нь өөрөө одоо юу гэдэг юм сайн дураараа төсвийн урсгал зардлыг тэлж байгаа хэрэг энд байхгүй.

Жишээлбэл, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа төсвийн урсгал зардал 2024 онд 28 хувь байсан

бол 2025 онд 27 хувь болж нэг хувиар буурч байгаа.

Магадгүй энэ цаашаагаа 2 хувиар, 4 хувиар буураад явах нь чухал байгаа.

Нөгөө талдаа бид Б.Жавхлан сайд уг аваад саяын нөгөө зөрүү тоонуудыг. Тийм ээ. Нэлээн тайлбарлаад ярих байх гэж бодож байна.

Нөгөө талдаа бид нарын өргөн барьж байгаа төсвийн хүрээний мэдэгдэлд ямар нэгэн байдлаар тооны зөрүү байхгүй. Өргөн барьсан төсөв яг үүнтэйгээ уялдаж гарч байгаа шүү гэдгийг хэлмээр байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Та бүхнийхээ энэ өглөөний амгаланг эрье.

Тэгээд 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт ингээд ороод ирсэн байна.

Энэ орж ирж байгаа төсөөллөөр 2025 онд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 8 хувь өснө. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33.8 их наяд болох нь. Нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ 35.7 их наяд болж төсвийн нийт дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 37.7 хувь болж өсөх буюу өнгөрсөн хугацаанд батлагдсанаас 4.4-өөс 4.5 их наяд хэмжээгээр ингээд өсөж орж ирж байна.

Энэ хэмжээгээрээ Монгол Улсын төсөв нэмэгдэж, төсвийн орлого зардал ч нэмэгдэхээр тооцоолоод ороод ирчихсэн.

Үүнийг ингээд харахаар итгэл үнэмшил бас төдийлөн төрөхөөргүй байгаа юм.

Нэгдүгээрт, 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 2027 оны төсвийн төсөөллийг яагаад хоёрхон сарын дотор өөрчлөөд ороод байгаа юм.

Ер нь энэ төсөв төлөвлөгөө батлах нэг зарчим гэж байгаа. Эхлээд төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн хуулиа хоёр, гурван жилийн өмнөөс нь баталчхаад тэр баталсан зүйлийнхээ дагуу төсвөө оруулж ирдэг байтал одоо төсөв нь орж ирээд төсөвтөө тааруулаад энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийнхөө төсөөллийнхөө хуулийг өөрчилж оруулж ирээд байгаа юм шиг санагдаад байна.

Тэгэхээр энэ дээр нэгдүгээрт хариулт өгөөч.

Хоёрдугаарт, дотоодын нийт бүтээгдэхүүн өслөө л гэж яриад байгаа.

Үнэхээр дотоодын нийт бүтээгдэхүүн 95 их наяд хүрээд нэг бол сайн тоо байх.

Нөгөө талдаа ард түмний чинь амьдрал ядуу хэвээрээ л байна. Хэд дахин өссөн ч юм, хэд дахин ч амьдрал хүндрэсээр байна.

Тэгэхээр энэ дотоодын нийт бүтээгдэхүүн тооцоолох тооцоолж байгаа аргачлал чинь яг ард түмнийхээ амьдралтай нийцэж байна уу? Аудитын дүгнэлтээс харахаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4 дээр дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцох арга, аргачлал нь адилгүй. Төсөөлсөн дүн нь материаллаг зөрүүтэй учраас дүгнэлт өгөх боломжгүй гэхсэн

байж байгаа. Үнэн бодитой гэсэн дүгнэлт өгөх боломжгүй.

Угаасаа дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг чинь 8 хувиар оруулж ирж байна. Дэлхийн банк 6.3-аас 6.6 дотор тооцоолж ирж байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 5.6-аас 6.7-д орж ирж. Монголбанк 7.3-аар оруулж ирсэн байна.

Ингээд энэ олон зөрүүтэй тоонуудыг чинь одоо яаж нэгтгэх юм бэ?

Ер нь төсвийн тухай хуулийн 27.1 дээр төсвийн төслийг төрийн мөнгөний бодлоготой нийцүүлсэн байна гээд байгаа юм.

Төрийн мөнгөний бодлоготой одоо юу гэж орж ирж байна вэ гэхээр төсвийн нийт зарлага өсөх юм бол инфляц нэмэгдэнэ. Монголбанкнаас төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрүүлэхгүй байх бодлоготой гэсэн ийм өгүүллүүдийг аудитын тайлан дээр тусгачихсан байж байгаа.

Угаасаа гадаад талын эдийн засаг дээр дэлхийн эдийн засгийн дотоодын нийт бүрэлдэхүүнийг бууралттайгаар тооцож байна.

Тийм учраас дотоодын нийт бүтээгдэхүүнээ тооцох тооцооллын аргачлалыг нэг болгож оруулж ирээч ээ. Энэ яагаад ийм олон янзын зөрүүтэй орж ирдэг юм. Угаасаа Монголбанканд орж ирж байгаа мөнгөний бодлоготойгоо нийцэхгүй байгаад байхад энэ дээр яагаад зөрүүдлээд ганцаараа өдрөөр орж ирээд байгаа юм бэ гэдэг нэг асуудал.

Хоёрдугаарт, төсвийн орлогыг хэтэрхий өөдрөгөөр тооцоолж байх шиг байна.

Нэг ёсондоо энэ жил одоо бид супер их тоо буюу 83 сая тонн нүүрс гаргана гэсэн байна. Энэ төсвийн орлогыг ингэж их тооцоолох. Нөгөө талдаа дотоодын нийт бүтээгдэхүүнийг ингэж ихээр тооцоолсон нь төсвийн орлого зарлагыг ихэсгэнэ.

Бодитойгоор зардал нь гараад явчихдаг. Орлого нь хүрэхгүй байгаа тохиолдолд энэ чинь эдийн засгийн хувьд бид илүү хямрал руу дөхөх эрсдэлтэй гэж үзээд байгаа юм.

Х.Булгантуяа: Б.Түвшин гишүүн шаардлагатай бол нэмээд тодруулчхаарай. Тэгэх үү? Л.Гантөмөр сайд хариулах уу? Б.Жавхлан сайд эхлээд хариулья.

Б.Жавхлан: Тийм. Ж.Баярмаа гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Тэр тийм арифметик математикийн ойлголт л доо.

Хууль дээр бол 2 гэж яг бүхэлчилж заасан байдаг. 2 гээд. Бүхэлчилнэ гэхээр арифметикаараа 2 хувь гэдэг маань энэ бол 1.5-аас их, 2.5 хүртэлх энэ хооронд депозон дотор.

Тэгэхээр 2 цэг 03 гэдэг бол 2 зууны 3 гэсэн үг. 2.1 ч биш, 2.3 ч биш. Үүнээсээ бага. Өөрөөр хэлбэл хазайлт нь 2-оосоо зууны 3 ийм пойнтоор давсан нь бол ер нь бүхэл 2 гэдэгтэй бүрэн нийцэхээр ийм хазайлт юм.

Тэгэхээр түүн дээр нэг их том зөрүү байхгүй гэж үзнэ.

Ер нь энэ аргачлаллийг тооцож эхэлснээс хойш л бүгд ингэж явж ирж байгаа. Тийм.

Х.Булгантуяа: Л.Гантөмөр сайд нэмж хариулья.

Л.Гантөмөр: Б.Түвшин гишүүний асуултад хариулья.

Бид ямар нэгэн байдлаар тоо зохиохгүй л дээ.

Энэ төсвийн хүрээний мэдэгдэлд ордог үндсэн 9 үзүүлэлт байгаа.

Та одоо энэ 9 үзүүлэлтийг харж байгаа. Энэ 9 үзүүлэлтийг ерөнхийдөө хувь хэмжээг нь Тогтвортой байдлын хуулиар ингээд тогтоочихсон.

Тэгээд 8 сарын 30-нд Төсвийн тогтвортой байдлын хууль өөрчлөгдсөнтэй холбогдуулаад 2025 оныхоо төсвийн хүрээний мэдэгдлийг л шинэчилж байгаа хэрэг.

Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хувь хэмжээг 8 хувь гэдгийг 2024 оны 6 сард баталчихсан тоо байхгүй юу даа.

Бид яг энэ 8 хувьдаа барина гэсэн ийм зорилт дэвшүүлж байгаа.

Ер нь олон улсын байгууллагууд, Валютын сан, Дэлхийн банк хүртэл хоорондоо зөрүүтэй тоогоор төсөөлдгийг Та мэдэж байгаа шүү дээ. Нэг тоогоор нэг амаар яриад байдаг байгууллага гэж байхгүй. Байгууллага болгон бие даасан өөрийн бодолтой, өөрийн онолтой, н өөрийн зарчимтай, өөрийн гэсэн төсөөлөлтэй байхгүй юу даа.

Х.Булгантуяа: Л.Гантөмөр даргад нэмж минут өгье.

Л.Гантөмөр: Тийм байгаа шүү. Гишүүн ээ.

Түүнээс биш төсөв боловсруулагдаад төсвөө дагаад төсвийн хүрээний мэдэгдэл гарч байгаа гэж ойлгож болохгүй.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 8 хувьтай гэдэг бол өнгөрсөн оны 6 сарын төсөөлөл шүү.

Тийм учраас шинээр зохиогоод Засгийн газар шинэ мөрөөдөл бий болгоод байгаа хэрэг биш гэдгийг нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт, дотоодын нийт бүтээгдэхүүнээ дагаад яг төсвийн хүрээнийхээ мэдэгдэлд алдагдал, ашиг гэдгийг нь их тодорхой заачихсан шүү дээ. 2 хувийн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл чинь өөрөө 2 хувийн зөрүүтэй байна. Түүнээс хэтэрч болохгүй гээд. Энэ тоогоо л барьж байгаа юм.

Нөгөө талдаа нүүрсний экспорт өнөөдөр 62 сая тонн хүрчихсэн байгаа.

Ноднин жилийн өдийд 43, 44 сая тонн байсан гэж байгаа юм. Тэгээд өнөөдөр.../минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Түвшин гишүүн тодруулья.

Б.Түвшин: Үнэхээр энэ тоонууд зөрүүтэй буюу Засгийн газраас орж ирж байгаа тоонууд нь хэт өөдрөг өсгөсөн байгаад байгаа учраас төсвийн

тэнцвэржүүлсэн орлого, төсвийн зардал, тэгээд бидний хэлдгээр тэнцвэржүүлсэн тэнцэл буюу алдагдал бодит тоогоороо 1 хувиар өсгөтөл 9 тэрбум төгрөгөөр зөрж өсөж байгаа шүү дээ.

Энэ утгаасаа та хэд бас анхаарах ёстой байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, аль ч намын мөрийн хөтөлбөр дээр ер нь л эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулна гэсэн.

Өнөөдөр бид бүгдээрээ 2025 оны төсвийн зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүний 37.7 хувиар оруулж ирж байгаа нь төрийн оролцоо маш өндөр хувьтай болж эхэлж байна.

Тэгэхээр энэ тал дээр бид гурван намын, ялангуяа гурван нам хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө зөрчөөд, эсвэл төсвийн оролцоог нэмэгдүүлэх ийм чиг хандлагууд гарч байна.

Цааш цаашдаа Их Хурал ч гэсэн шийдвэр гаргахдаа, ялангуяа Х.Булгантуяа дарга.../минут дуусав/

Х.Булгантуяа: Л.Гантөмөр сайд нэмж хариулья.

Л.Гантөмөр: Гишүүнтэй санал нэг байна. Төр хувийн хэвшилтэйгээ өрсөлдөхгүй.

Энэ удаагийн төсөв Та бүхэн араас нь хэлэлцэнэ.

Энэ удаагийн төсөв бол үнэхээр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй гэсэн маш их том эрмэлзэлтэй төсөв шүү.

Зөвхөн дэд бүтэц рүү хөрөнгө оруулна.

Энэ төсөв яагаад өсөөд байгааг бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Улаанбаатар хот руу хийж байгаа хөрөнгө оруулалтынхаа хэмжээг бид урьд хожид байгаагүй буюу 4 их наяд руу хүргэж байгаатай л холбоотой.

Яагаад Улаанбаатар хот руу энэ их дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийгээд байна вэ гэхээр энэ түгжрэлээс хэдүүлээ салах хэрэгтэй болчихсон.

Салахгүй хэдүүлээ ингээд л зовоод байж болно. Тэр нэг сонголт. Салъя гэдэг зориг гаргаж байгаа нь бидний, одоо таны санаа зовоож байгаа асуудал тэнд л байгаа юм.

Тийм учраас энэ утаа арилгах, түгжрэл арилгах, цэвэр бохир ус, эрчим хүчтэй болоход зориулагдсан төсөв учраас энэ дээр.../минут дуусав/

Х.Булгантуяа: Гишүүний асуулт асуух нь 4 минутаас илүүгүй. Нэмэлт асуух бол 1 минутаас илүүгүй. Хариулт тайлбар хангалтгүй гэж үзэх юм бол гишүүн 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж болно гэж байгаа.

Б.Түвшин гишүүн нэмж тодруулах уу? Тэгье.

Б.Түвшин: Тэгэхээр ялангуяа төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл чинь макро эдийн засгийн томоохон бодлогын асуудал.

Иймэрхүү хугацаанд Их Хурлын гишүүд мэддэг мэддэггүйгээрээ яриад хэлэлцэхээсээ илүү урьдчилсан суурь судалгаатай орж ирэх ёстой.

Тэр хуулийн 27.1.6 дээр Монголбанкныхаа мөнгөний бодлоготой уялдахгүй бол төсвийн зардал ихсэх юм бол инфляц өснө л гэсэн байгаа. Тэгээд энэ талаас би тодорхой авчихлаа.

Цаашдаа Улсын Их Хурлын даргын захирамжаар гарсан Улсын Их Хурлыг Стратеги төлөвлөгөөний хууль дээр, ялангуяа Х.Булгантуяа дарга энэ Их Хурлын гишүүд, ялангуяа Их Хурлаас гарч байгаа шийдвэр өөрөө мэргэжлийн судлаачдын дүгнэлт шинжилгээн дээрээ суурилсан байх гэдэг дээр заавал оруулж өгөөрэй гэж хүсэх байна.

Х.Булгантуяа: Б.Түвшин гишүүн санал хэллээ. Чухал санал хэллээ. Энэ бол яг стратеги төлөвлөгөөнд орж байгаа нэг том ажил бол Улсын Их Хурал шинжлэх ухаанч байна гээд.

Энэ дээр хууль өргөн барьж байгаа Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн өөрснөө хууль өргөн барьж болно.

Тэгэхэд заримдаа нэг талыг давамгайлсан судалгаа хийгээд өргөн барьчихдаг. Ийм тохиолдолд манай Улсын Их Хурлын Тамгын газрын Сургалт судалгааны хүрээлэнгээс олон талын судалгаа бид хийлгэж авч үзэж харах бүрэн эрхтэй. Ийм байж байж манай Улсын Их Хурлаас гарч байгаа хууль маань олон талын үзэл санааг шингээсэн шинжлэх ухаанч хууль тогтоомж дараа нь амьдрал дээр илүү хэрэгжих хууль байна гээд Б.Түвшин гишүүний гаргаж байгаа саналтай санал нэг байна.

Дараагийн гишүүн Пүрэвжавын Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Энэ макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болсон, ялангуяа 2025 оны төсвийн үндсэн суурь болох төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 2027 оны төсвийн таамаглалын гол асуудлуудыг бид хэлэлцэж байна.

Тэгэхээр хоёр асуулт байна.

Нэгд, би энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуумаар байна. 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 2027 оны төсвийн таамаглалын Хууль зүйн сайдын өгсөн дүгнэлт болохоор “хуульд нийцэж байна” гээд өргөн барьчхаж байгаа.

Гэтэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлт дээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.8, 28.4-ийг зөрчсөн гээд дүгнэлтдээ оруулчихсан байж байгаа.

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.6, 16.5.1-ийг хэрэгжүүлээгүй гээд.

Тэгэхээр энэ чухал асуудал хэлэлцэж байхад тодорхой хуулийн заалтууд нь зөрүүтэй байна гээд Их Хурлын харьяа байгууллага нь ингэж дүгнээд байдаг. Засгийн газраас өргөн барихдаа хууль зөрчөөгүй гээд байна.

Тэгэхээр в Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс яг энэ асуудал дээр ойлгомжгүй байдал үүсээд байгаа болохоор тодорхой тайлбар өгөөч гэж хүсэж байна.

Хоёрт, төсвийн хүрээний 2025 оны мэдэгдэл дээр инфляцыг 7.5 байна гээд. Яах вэ өмнөхөөсөө тодотгоод өсгөөд тооцож байгаа.

Тэгэхээр ирэх жил томоохон мега төслүүд явна. Энэ төслүүд явахтай холбоотой зах зээл дээр тодорхой бүтээгдэхүүнүүдийг нь. Тухайлбал, мянган километр зам барина гээд тавьчихсан байж байгаа. Том том бүтээн байгуулалтын ажлууд явна гэж байгаа.

Тэгэхээр дизель түлшний хэрэглээ жишээлбэл огцом нэмэгдэнэ.

Тэгэхээр эрчим хүчний сайдаас асуумаар байна л даа. Энэ хэр хэмжээгээр нэмэгдэх вэ? Энэ эрэлтээ хангаж чадах уу? Үнэ тогтвортой байх уу?

Энэ бол яг энэ өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлдөг гол хүчин зүйл. Мөн дулаан цахилгааны үнэ дээр бид реформ хийнэ гээд байгаа. Үе шаттай үнэ тарифыг нь нэмэгдүүлнэ гээд байгаа. Энэ маань хэдэн хувиар яаж нэмэгдэх юм бэ? Энэ маань инфляцад маань яаж нөлөөлөхөөр тооцсон байгаа вэ гэдгийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуумаар байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Эхлээд Л.Гантөмөр сайд хариулах уу? И.Батхүү дарга. 4 номерын микрофон байна уу? Тийм ээ. И.Батхүү дарга. Ажлын хэсгийн 6 номерын микрофон. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү хариулна.

И.Батхүү: Гишүүний асуултад хариулья.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр орсон өөрчлөлтөөр Засгийн газрын өрийн хэмжээг нэрлэсэн дүнгээр тооцдог болсон.

Энэ өөрчлөлтөөр Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг 2025 онд 55 хувь, 2026 онд 50 хувь, 2027 онд 45 хувьтай байхаар тооцсон.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан 2025 оны төсвийн жилээс эхлэн Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 60 хувиас хэтрүүлэхгүй гэсэн хуулийн шаардлагыг хангаж байгаа.

Инфляцтай холбоотой асуудал дээр 2024 оноос эхлээд эрчим хүчний либералчлалыг эхлүүлэхээр Засгийн газар зорилго тавиад ажиллаж байгаа.

Энэ хүрээнд тухайлбал цахилгаан дулааны тариф нэмэгдэх асуудлын тооцоолол, хувилбарууд хийгдээд явж байгаа.

Нийт 2 жил дамнаад 2 орчим нэгж хувийн инфляцын нөлөөлөл байгаа гэж үзэж байгаа. Шууд болон шууд бусаар.

Энэ нь дулаан, цахилгааны тарифын нэмэгдлийнхээ хувилбараас шалтгаалаад хэд хэдэн хувиар гарч болохоор байгаа.

Бид ер нь ирэх оны төсвийн инфляцын төсөөллийг 7.5 гэж гаргахдаа энэ инфляцын гарч болзошгүй нэмэгдлийг бас тооцож оруулсан байгаа.

Х.Булгантуяа: П.Ганзориг гишүүн тодруулъя.

П.Ганзориг: Би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан дүгнэлт дээр тодорхой хуулийн

заалтуудыг зөрчсөн, бас хэрэгжүүлээгүй байна гээд тусгачихсан байгаа юм.

Засгийн газраас өргөн барихдаа Хууль зүйн сайд нь хуульд нийцэж байна гээд өргөн барьчихсан. Их Хурлын харьяа байгууллага нь ингээд дүгнэхээд байгаа болохоор энэ ойлгомжгүй байдал дээрээ нэг тодорхой хариулт өгөөч ээ.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс яг тэр хуулийн тодорхой заалтуудыг би сая дурдлаа шүү дээ. 4 заалт байгаа.

Тухайлбал, яг зөрчсөн гээд байгаа нь 12.1.8, 28.4 2-ыг зөрчсөн гээд энэ дээр биччихсэн байна шүү дээ.

16.6, 16.5.1-ийг хэрэгжүүлээгүй гээд.

Яг энэ дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тодорхой хариулт өгөөч.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 5 номерын микрофон. Намжилдоржийн Энхбаяр. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга. 5 номерын ажлын хэсгийн микрофоныг өгье.

Н.Энхбаяр: Сайн байцгаана уу? Эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

П.Ганзориг гишүүний асуултад хариулахаас өмнө эхний удаагийн асуултад хариулж байгаа учраас би ерөнхийд нь нэг зүйл хэлье гэж бодож байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 1 сард Улсын Их Хурлын

чуулганы энэ танхимд би томилогдсон. 4 жилийн хугацаатай ажиллаж байгаа.

Хуулиар хүлээсэн үүрэг маань төсвийн тогтвортой байдлыг хангах. Энэ чиглэлээр төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, гүйцэтгэл гээд эдгээр бичиг баримтад санал, дүгнэлтээ гаргах ёстой ийм чиг үүрэгтэй байгууллага.

Ингээд төсвийн хэлэлцэх маань бодлогын чухал шийдвэр учраас бид мэдээж олон талаас нь олон өнцгөөс нь асуудлыг харж шийдвэрлэх ёстой. Энэ агуулгаараа төсвийн тогтвортой байдлын зүйлээс бас учирч болзошгүй эрсдэлүүдийг анхааруулж хэлж байгаа.

Тэгэхээр одоогийн бидний анхааруулаад байгаа зүйл анх удаа тулгамдах гээд байгаа зүйлийг бид хэлээд байгаа юм биш. Хамгийн гол нь. Энэ бол бидний туулаад ирчихсэн түүх байхгүй юу.

2015, 2016 онд эдийн засаг саараад бид 2016 оны намар 8 жилийн өмнө Засгийн газар макро эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг баталж байсныг Та бүхэн манай Их Хурлын зарим гишүүд ч мартаагүй санаж байгаа байх.

Эргээд 2018, 2019, ингээд 2020 онууд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Микрофоны хугацаа ямар богинохон байна. 7 номерын микрофон. Ажлын хэсгийн 7 номер.

Н.Ууганбаатар: Сайн байна уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар байна.

Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулсан байдалтай холбоотой П.Ганзориг гишүүний асуултад хариулъя.

Энэ дээр тухайлбал өргөн баригдсан хуулийн төслийн 9 үзүүлэлтийн 8 дугаар үзүүлэлт дээр Засгийн газрын өрийн нийт хэмжээ дээд түвшнээр гэсэн байгаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд дээд түвшнөөр гэсэн агуулга байхгүй.

Тэр өрийг точный өгөх ёстой. Эдийн засаг, хөгжлийн яам маань дээд түвшнээр оруулж ирсэн.

Түрүүчийн Ж.Баярмаа гишүүний асуугаад байгаа төсвийн төсөл дээр гараад байгаа суурь зарлага болон энэ дээр байгаа суурь зарлагын хоорондын зөрүү юунаас үүсэж байгаа вэ гэхээр эндээс үүсэлтэй байгаа.

Эдийн засаг, хөгжлийн яам маань дээд түвшнээр гээд тооцоо хийгээд өгчихсөн. Түүнээс болоод өрөө илүү их өр хассан гэсэн үг.

Тэгэхээр суурь зарлага илүү бага гарсан гэсэн үг.

Тэгэхээр энэ бол Эдийн засаг, хөгжлийн яам энэ дээр алдаа гаргасан юм болов уу гэж бодож байна.

Дараа нь дахиад Тогтвортой байдлын тухай хуулийн 12.3-т дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах агуулгатай гээд дотроо ямар байх вэ гэдгийг точный заагаад өгчихсөн байгаа юм.

Гэтэл бидэнд ирсэн бичиг баримт бол ердөө 19 хуудас. Тэгээд энэ дээр тодорхой агуулгууд огт байхгүй. Макро эдийн засгийн тогтвортой байдал, төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ, макро эдийн засгийн төлөв.../минут дуусав/

Х.Булгантуяа: 3 минут дээр нэмж 1 минутаар хариулахаар байгаа.

Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Энэ төсвийн хүрээний өмнөх мэдэгдлүүд төсвийн төсөөллийн хуулиудаа та нар хараарай.

Ер нь сүүлийн жилүүдэд төсвийн хүрээний мэдэгдэл батлахдаа саяын хүний хэлдэг Засгийн газрын өрийн нийт хэмжээ гэдгээ дандаа дээд хэмжээгээр аваад явчихсан юм билээ. Ийм л юм байна лээ шүү дээ.

Тэгээд л энэ жил адилхан тэгээд л орж ирж байгаа юм.

Одоо та нар ингээд яамаар тоглож болохгүй ээ. Засгийн газар нэгдмэл байр суурьтай байдаг юм.

Ерөөсөө Монголын парламентын өнөөдөр хийж байсан хамгийн том алдаа юу вэ гэхээр яам яамаар нь салгаж бодлогын мэтгэлцээн рүү оруулдаг.

Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам хоёр бол хоёр тусдаа бүтэц биш ээ. Засгийн газар гэж Монгол Улсад нэг л байгууллага байгаа. Энэ Засгийн газар л өргөн барьдаг. Энэ Засгийн газар л Их Хуралд ажлаа тайлагнадаг. Тэгэхгүй ингээд яамаар нь хагалаад, сайдыг нь зодолдуулаад өнөөдөр хүртэл ингэж явж ирсэн.

Цаашдаа би Тэргүүн Шадар сайдын хувьд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Яах вэ, П.Ганзориг гишүүний асуугаад байгаа зөв л дөө. Хууль зүйн яамнаас нь ийм дүгнэлттэй байхад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өөр дүгнэлт гаргасан байна. Альныг нь бид нар авч үзэх ёстой юм бэ гэж.

Тийм. Хууль зүйн яамнаас. Хууль зүйн яамнаас одоо энэ бол хууль зөрчөөгүй гэсэн дүгнэлт гаргасан байна. Тэгсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болохоороо өөр дүгнэлт гаргасан байна гэж байна.

П.Ганзориг гишүүн, тодруулъя.

П.Ганзориг: Төсөв өргөн барихдаа хуульд нийцэж байна гээд Хууль зүйн сайд нь гарын үсэг зураад өргөн барьчихаж байгаа шүү дээ.

Тэгээд дараа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт дээр чинь маш тодорхой биччихсэн байна шүү дээ.

Би сая заалтуудыг нь уншлаа. 2 заалт зөрчсөн, 2 заалтыг хэрэгжүүлээгүй гээд. Тэгээд ингээд хоёр зөрүүтэй юм чинь Их Хурлын гишүүд ойлгомжгүй байдал үүсгээд байна шүү дээ. Энэ дээрээ нэг тодорхой хариулт өгөөч ээ. Ялангуяа энэ хууль зөрчсөн гэж дүгнээд байгаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь тайлбар өгвөл зохимжтой болов уу гэж бодож байгаа юм.

Хоёрт, түрүүн нөгөө Эрчим хүчний сайдаас асуусан. Дизель түлшний үнэ инфляцад яаж нөлөөлөх. Ирэх

жилүүдэд том бүтээн байгуулалтууд явахтай холбоотой эрэлт нэмэгдэнэ. Эрэлт, нийлүүлэлт яаж зохицуулах вэ, үнэ ямар байх вэ гэдэг дээр хариу өгсөнгүй.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нэмж хариулах уу?

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуугаад байх шиг байх юм. Б.Жавхлан сайд хариулах юм уу? Л.Гантөмөр сайд буруу ойлгоод байна.

Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүйн яам хоёр хоорондоо зөрүүтэй юм яриад байна гэж яриагүй.

Б.Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Би П.Ганзориг гишүүний асуулт дээр нэмэлт тодруулга өгье.

Төсвийн хүрээ гэдэг өөрөө хуулийн заалтаар энд орж ирж байгаа энэ макро тоонууд чинь цөөхөн тоо байгаа шүү дээ. Одоо 11 тоо.

Энэ хүрээ гэдэг чинь дандаа хязгаар тоонууд байхгүй юу. Хязгаар тоо.

Энэ хязгаартаа багтаад төсвийн хуулиа, төсвөө өргөн барьдаг.

Одоо өр дээр жишээ нь 60 хувь. Ирэх жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн хэрвээ 95, 96 их наяд болно гэж байгаа бол төсвийн хүрээн дээр орж ирэх өрийн хэмжээ маань 60 хувь буюу нөгөө тусгай шаардлагынхаа дээд хэмжээгээр л тийм тоо орж ирнэ. Үүнээс хэтэрч болохгүй шүү гэдэг ийм хуулийн ойлголт байхгүй юу.

Бид төсвөө өргөн барихдаа тэр 60 дотроо бариад Засгийн газрын өөрийнхөө Их Хурлаас гаргасан дунд хугацааны стратегийн бодлогоор тэр даалгаврынхаа дагуу багтааж оруулж ирнэ.

Тэр нь ирэх жил гүйцэтгэлээрээ бид 42 орчим л хувь гарна. Гүйцэтгэлээр 2025 онд.

Х.Булгантуяа: Харин тийм. Б.Жавхлан сайдад нэмж микрофон өгье.

Маш тодорхой хариулмаар байна. Тодорхой асуусан шүү дээ. Уг нь. Тийм ээ. Харин тийм. Б.Жавхлан сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Тийм. Уг нь би хэлэх гээд л ядаад байна л даа.

Төсвийн хүрээ бол одоо Засгийн газар өрийн хэмжээ дээд хязгаар нөгөө тусгай шаардлагаараа 60 хувь. Дотоодын нийт бүтээгдэхүүн гэдгээ гаргачихсан. Тэрний 60 хувь гээд маш тодорхой дүнгээ л тавина. Энэ дотор байна шүү гээд.

Бид төсвөө оруулж ирэхдээ 45 хувь дээр орж ирж байгаа. Удахгүй хэдүүлээ төсөв яриад эхэлнэ. Тэр дээр илүү дахиад ярилцаад тодорхой болгоё л доо. Тоонуудаа яриад. Тийм.

Тэгэхээр тэнд хууль зөрчсөн зүйл ерөөсөө огтоос байхгүй шүү. Яах вэ, жоохон ойлголтын зөрүү байх шиг байна.

Хүрээ гэдэг бол гүйцэтгэлийн дүн биш шүү. Энэ бол төсөв биш. Энэ бол зүгээр л хязгаар тоонууд. Зүгээр ч юу байх вэ, энэ дотор байна шүү, энэ дотор амьдарна шүү, энэ дотор төлөвлөнө шүү гэдэг л ийм хязгаарууд байгаа юм.

Х.Булгантуяа: Нэмж тодруулж байж. П.Ганзориг гишүүн чинь хоёр удаа тодруулсан, нэгтодруулсан уу? Нэг тодруулсан байх. Хоёр тодруулчихсан уу?

Хэрвээ хоёр тодруулчихсан бол болчихсон. Хоёр тодруулчихсан. Тийм ээ. Н.Наранцогт оо. Тийм. Дэгээрээ бол болчихсон.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тайлбарлаадахья. Өөрсдөө тайлбараа. Хэдэн номерын микрофон байна. Ажлын хэсгийн 7 номерын микрофон.

Н.Ууганбаатар: Хууль тайлбарлах эрх бидэнд байхгүй. Хууль дээр бичигдсэн байдлаар “дээд хэмжээ” гэдэг үг хууль дээр байхгүй.

Өмнө нь батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлүүд дээр ч гэсэн энэ байхгүй. “Нийт хэмжээ” л гэсэн дүн байгаа.

Тэгээд түүний цаана “дээд хэмжээ” гэсэн агуулга байсан уу, үгүй юу гэдэг асуудал бидний эрх хүрээний асуудал биш байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол зөвлөмж бид нарт гаргаж өгч байгаа. Хууль зөрчсөн эсэх талаар.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Түрүүний өрийн асуудал дээр санаа зовж байгаа асуудал байгаа.

Тэр зам гүүр, эрчим хүчний асуудал үнэхээр чухал. Үүнийг хийх ёстой. Гэхдээ нэг зүйл дээр өнгөрсөн туршлагыг харж байхад эхний оруулж ирж байгаа төслүүд нь ерөнхийдөө оруулж ирж батлуулж байгаад дараа нь яадаг вэ гэхээр дахин төсөв тодотгох хэрэгтэй байна, төслүүд хүрэлцэхээ байлаа гээд анхны төсөвлөж оруулж ирсэн төслүүд маань хоёр дахин, гурав дахин өртөгтэй болоод ингээд хэдэн жил дамнасан орхиж ч болдоггүй, хаяж ч болдоггүй гэдэг байдлаар төсөвт өртгүүд нэлээн өндөр өсчихдөг тийм зүйл бас ажиглагдаад байгаа.

Энэ нь алсдаа төсөв нь дийлэхгүй, өрөө эргэж төлж дийлэхгүй байдалтай. Энэ нь эргээд нийгмийн зардлуудаа танах юм руу бид нэг удаа бас орж үзэж байсан.

Тийм учраас ийм эрсдэл ирээдүйд гарахгүй гэх баталгаа байна уу? Энэ техник, эдийн засгийн үндэслэл энэ төсөвт томоохон төслүүдийн маань өртөг цааш нь ер нь өсөх, үнэ тарифтайгаа холбоотойгоор өсөх ийм эрсдэлүүд байгаа юу? Үүнийг хэрхэн тооцож байгаа вэ гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт, “нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн” гэдэг үзүүлэлтийг одоо олон улсад нэг их эдийн засгийн гол үзүүлэлт гэж харахаасаа илүүтэйгээр нийт өсөлт өөрөө хэр зэрэг хүн амын хэдэн хувьд ногдож байна вэ гэдэг зүйлийг хараад байгаа юм. Үүнийг “жини коэффициент”¹-ээр гаргадаг.

Тэгэхээр ирээдүйд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээс

¹ Хүн амын зардлын тэнцүү бус хуваарилалтыг илэрхийлсэн коэффициент.

гадна энэ жини коэффициентийг хэд болгоё гэж төсөөлж байгаа юм бэ? Энэ том том төслүүдийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч ажиллах хүчнээр дамжуулаад цалин хөлс, татвар, нийгмийн даатгал руу хэдэн төгрөг орох вэ гэдэг энэ тооцооллуудыг би дахин дахин л хэлээд байгаа. Хийж байгаа юу гэдгийг хэлмээр байна.

Мөн төсөвт одоо ирээдүйд санаа зовж байгаа зүйл бол бүх оронд л байдаг. Энэ эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн даацын асуудал гэж байгаа. Энэ тал дээрээ бид нэлээн оновчтой бодлогуудыг цааш нь бодож явахгүй бол эргээд энэ төсөв рүүгээ хүндрэл авчрах ийм зүйл рүү бас орох магадлалтай байгаа.

Ирэх жил энэ тал дээрээ давхар анхаарч явахгүй бол. Энэ жилдээ орхичихъё гэх юм бол тэрний хойтон жил бүр их хүндрэх асуудал гарч магадгүй.

Өчигдөр би эрүүл мэндийнхэнтэй бас уулзлаа. Мөн боловсролынхонтой уулзлаа. 2030 он гэхэд нийт хүүхдийн суудлын тоог стандартад аваачихад 2.7 их наяд төгрөг шаардлагатай гэж тийм тооцоо хийсэн байна лээ. Боловсролын яамны мэргэжилтнүүд. 2.7 их наяд төгрөг.

Тэгэхээр ирэх жилүүдэд яах вэ, 90-ээд сургууль, цэцэрлэг баригдаж ашиглалтад орно. Цаашаагаа дахиад хэрэгцээнүүд байгаа юм билээ. Одоо ингээд боллоо гэж үзэж болохгүй.

Мөн дээрээс нь дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх цалин хөлс, орлогын хэмжээ гэдэг нэг үзүүлэлт байгаад байгаа юм. Үүнийгээ хэрхэн төсөөлж байгаа вэ?

Одоогоор миний харж байгаагаар 25 орчим хувь байгаа юм.

Ерөнхийдөө дундаж ангиа тэлье гэсэн бодлогуудыг бүх л намууд дэвшүүлж байсан. Энэ нь өөрөө 40, 50 хувьтай байж тэр дундаж анги нь өөрөө тэлдэг. Цалин хөлс. Иргэдийн гар дээр очиж байгаа мөнгө гэсэн үг.

Тэгэхээр энэ бодлогуудаа давхар авч явахгүй бол бид нийгмийн ард түмний хүсэн хүлээд байгаа миний өрхийн хаалгаар орлого орохгүй байна гэдэг зүйлүүд рүү ирэх жилүүд рүү биднээс нэхэж эхлэх ийм зүйл байгаа.

Орон сууц дээр ганц зүйл хэлчихье. Орон сууцын дэд бүтцийг татаж өгөх нь зөв өө. 150 мянган айлын орон сууц гээд байж байгаа.

Гэхдээ аж ахуйн нэгж, байгууллагуудад замыг нь тавьж өгөөд, дэд бүтцийг нь тавиад өгдөг. Үнэ тарифаа хэрхэн яаж барих юм бэ? Нөгөө бага, дунд орлоготой иргэдээ энэ хувийн хэвшил, төр гэхээсээ гадна худалдаж авах гэж байгаа хүмүүстээ гуравласан гэрээ гэдэг ийм асуудлуудыг давхар тавихгүй бол нөгөө цемент өсдөг, нөгөө барилгын үнүүд нь дахиад өсчихдөг. Ард иргэдийн гар дээр очиж байгаа метр квадратын үнэ.../минут дуусав/

Х.Булгантуяа: Л.Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Өнөөдөр яг одоо бид нарын хэлэлцэж байгаа зүйл бол 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл байгаа.

Төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд түрүүн Б.Жавхлан сайд хэлсэн. 11 тоог ярина.

Тэгээд С.Эрдэнэбат гишүүний асууж байгаа асуултуудад яг төсөв хэлэлцэх үеэр маш тодорхой хариултуудыг өгнө. Баярлалаа.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулах уу? Энэ том төсөл, хөтөлбөрүүд төсөвт өртөг нь ахиад нэмэгдчих юм биш биз дээ. Тэгэх юм бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр ахиад өөрчлөлт орохоор нөхцөл байдал үүсэх юм биш биз дээ. Та бүхэн түүнийгээ тооцсон уу гээд хэд хэдэн асуултууд асуусан.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Энэ дээр тавьсан тоонууд маань дандаа дээд хязгаарууд.

С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулж байгаа шүү. Тийм. Дандаа дээд хязгаар тоонууд учраас эндээ л бид хязгаарлагдаж төсвөө өргөн барьсан байгаа.

Тийм учраас бид аль болох эндээ хязгаартаа багтаагаад л хөрөнгө оруулалт энэ алхмуудаа тааруулаад л явдаг.

Төсөв өргөн баригдсан байгаа. Нэг сар гаруй бид хэлэлцлээ. Тэгээд төсөв хэлэлцээд эхлэхээр энэ асуудлуудыг бүр нэг бүрчлэн дэлгэрэнгүй ярина.

Саяын таны ярьж байгаа зарлага дотор бүр задлаад цалин хөлс гээд явах юм бол энэ хүрэн дээр ярилцах асуудал биш л дээ. Хүрэн дээр нийт зарлага дотроо орчихсон явж байгаа.

Тийм учраас яг төсөв яриад эхлэх үед таны асуудлууд дээр илүү их дэлгэрэнгүй хэдүүлээ задлаад ярилцъя.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн маань тэр хүрээний 8 дугаар заалт буюу Засгийн газрын өрийн нийт хэмжээ гээд таслал ард нь дээд түвшнөөр тэрбум төгрөг гээд ингэж оруулсан байдаг шүү.

Энэ бол яг нөгөө тусгай шаардлагаараа оруулж ирэх ёстой дүн гэдгийг нь хуульд ингэж их тодорхой ойлгомжтой болгох гэж дахин тодруулж оруулсан байгааг Та бүхэн маань эргээд нэг хараарай.

Бид энэ хүрээг сүүлийн бараг 20 гаруй жил хэрэглэж байна шүү дээ. Тэгэхэд дандаа л ингэж явж ирсэн байдаг юм.

Тэгээд энэ удаа яг өмнөх шигээ ийм ойлголттой энэ хуулиа ингэж ойлгоод оруулаад ирэхээр хууль зөрчсөн байна гэдэг ийм дүгнэлт өөрөө арай л нийцэхгүй байна даа. Үүнийг нэг эргэж харна биз дээ.

Ер нь хамтарсан Засгийн газрын анхны төсөв. Төсвийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Одоо ингээд Төсвийн тухай хуулиа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Засгийн газар хоёр маань хоёр өөрөөр ойлгоод, хоёр өөр дүгнэлт гаргаад Улсын Их Хурлын гишүүдэд өгөөд байвал хэцүү шүү.

Та бүхэн маань ойлголтоо нэг болгоорой.

Улсын Их Хурлын гишүүд аль ойлголтыг нь зөв гэж барьж явах юм. Хэцүү шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан. Л.Мөнхбаясгалан гишүүн байхгүй байна уу? Л.Мөнхбаясгалан гишүүн байхгүй байна.

Энхбаярын Батшугар.

Э.Батшугар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Макро түвшинд асуудал ярьж байгаа болохоор макро түвшний асуулт асууя л даа.

Гол нь төлбөрийн тэнцэл дээр ирэх онуудад ямар дарамт ирэх вэ?

Гол нь геополитик болон гадаад улсын эдийн засгийн байдлыг харахад сонин нөхцөл байдал үүсээд байгаа юм.

Тэр нь юу вэ гэхээр Та бүхэн мэдэж байгаа байх. Америкийн инфляц болон үнийн өсөлт нь буураад үүгээрээ дамжуулаад сая Төв банк нь 4 жилдээ анх удаа 0.5 хувиар бодлогын хүүгээ бууруулсан.

Мөн 11 сард ахиад бууруулах тийм таамаглал мессеж өгсөн. Үүнтэй холбоотойгоор нийт Америкийн үнэт цаас эзэмшдэг Хятадууд байгаа юм. Хөрөнгө оруулагч нар. 2 их наяд долларын үнэт цаас эзэмшдэг.

Америкийн үнэт цаасын өгөөж нь буурахаар тэд нар эргээд 50 хувь нь дор

хаяж буцаад Хятад Улс руугаа арай өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх гээд орно.

Энэ нь RMP[Risk Management Plan] гэж байгаа юм. Бидний хэлдгээр юанийн ханшийг дунджаар 10 хувиар өсгөнө гэсэн тийм таамаглал шинжээчид тавьж байгаа юм.

Энэ бол манай Монгол Улсын төлбөрийн тэнцэл дээр шууд дарамт үүсгэнэ. Яагаад гэвэл бид нийт бараа, бүтээгдэхүүнийхээ 60 хувийг Хятадаас импортоор авдаг.

Энэ төсөөлөл одоо орсон байгаа юу? Макро чиглэлийн төсөөлөл.

Хоёрт нь, нэг ийм парадокс байгаад байгаа юм. Монгол Улсад. Энэ нь манай “мөнгөний нийлүүлэлт буюу M2” гэж үзүүлэлт байдаг. Үүнтэй холбоотойгоор манай улсын төсвийн орлого.

Энэ коэффициент олон улсад 10-аас 15 хувь. Хөгжиж байгаа Монгол шиг улс орондоо үсрээд л 25 хувьтай явдаг.

Харин манайд энэ тоо маш өндөр яваад байгаа юм л даа. Жишээлбэл, 2022 онд 58 хувьтай. 2023 онд 62 хувьтай. Эхний 8 сарын байдлаар 2024 онд 45 хувьтай.

Тэгэхээр энэ нь онолоороо яадаг вэ гэхээр хувийн сектороо төр засаг нь мөнгөний чөлөөт урсгалыг нь хурааж авч байгаа “Crowding Out Effect” гэсэн нэг онол байдаг. Энэ парадокс одоо үе шаттайгаар яаж гарч илүү хувийн салбараа дэмжих вэ гэдэг л хоёр асуулт байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Л.Гантөмөр сайд хариульъя.

Л.Гантөмөр: Мэдээж зах дээр мөнгө нийлүүлэгдэхээр импорт нэмэгдэнэ. Үүнтэй холбоотойгоор төлбөрийн тэнцэлд эрсдэл байгаа.

Хамгийн гол нь бидний барьж байгаа байр суурь бол экспортынхоо хэмжээг л алдахгүй байхыг зорьж байна. 19 тэрбум долларыг ирэх онд экспортоос олно гэсэн ийм тооцоолол байна.

Тэгэхээр Хятадад бараа, бүтээгдэхүүний үнэ өснө гэж би харахгүй байна. Юанийн ханш өсөх нь өөрөө шууд бараа, бүтээгдэхүүний үнэд наашаагаа нөлөөлөхгүй ээ.

Ер нь Хятадын зах зээл өөрөө зах нь өөрөө таны хэлж байгаа тэр мөнгөн дүнг татахад бэлэн байгаа.

Одоогоор Хятадын нийт эдийн засаг агшчихсан. Засгийн газар нь хүчээр injection_[тарилга] хийгээд яваад байна шүү дээ. Үүнийг хөрөнгө оруулалтын урсгал өөрөө нөхчихнө.

Одоо Америкийн Төв банкны хүү буурахаар аяндаа мөнгө эргээд гараад ирнэ гэж та хараад байна шүү дээ. Гарч ирсэн мөнгө чинь өөрөө Хятад руу орох багтаамж нь хангалттай байгаа.

Тийм учраас энэ эрсдэлийг харахгүй байна. Гол эрсдэл бол одоо энэ Израильд болж байгаа Ойрхи Дорнодын мөргөлдөөн байна.

Хэрвээ Иран энэ дайнд татагдаж орох юм бол газрын тосны үнэ өсөх магадлалтай байна. Хэрвээ газрын тосны үнэ өсөөд газрын тосны хомсдол бий

боллох юм бол манайх уул уурхайн салбараас хэт хамааралтай учраас. Таны хоёр дахь асуулт тэр байна шүү дээ. Уул уурхайн салбараас хэт хамааралтай учраас манай орлого их өндөр харагдаад байгаа юм.

Бусад салбарууд цэцэглээд бусад салбарууд нь балансаа бариад эхлэх юм бол аандаа орлого өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлдэг хувь нь багасаад эхлэх юм.

Өнөөдөр бодитой эдийн засагт байгаа жижиг, дунд үйлдвэрлэгч нарын үүрэг роль яагаад ийм бага байгаа юм бэ гэхээр уул уурхай нь хэтэрхий том байгаа байхгүй юу. Экспортын чинь 90 хувь. Тийм ээ.

Ингээд харахаар зэрэг яалт ч үгүй энэ балансын хувьд. Одоо би эхний 100 татвар төлөгчийг хараад байгаа байхгүй юу. Хэн байна, яаж төлж байна, ямар хэмжээтэй байна, төлж чадаж байна уу. Өнгөрсөн 3 жилийнх нь график гээд үүнийг бид нар бүгдийг нь харж байгаа.

Энэ дээр уул уурхай дээрээ өндөр учраас орлого нь ингэж өндөр. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа орлого нь өндөр харагдаад байгаа байхгүй юу даа.

Тийм учраас эрсдэлээ бид харж байгаа. Хамгийн том эрсдэл бол одоо тэр Ойрхи Дорнодын дайн цаашаагаа ужгирах юм бол бид нарын гол нөгөө үйлдвэрлэлд ашигладаг зүйл чинь нефть байна шүү дээ. Нефтийн болоод бензиний үнэ хөдлөхөд бид асуудал ярьж эхлэх болно. Энэ бол хамгийн том эрсдэл байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Түүнээс бид огт эрсдэл харахгүй байгаа тухай ийм ойлголт алга.

Нөгөөдөх нь бидний төлөвлөж байгаа том төслүүдийг Их Хурал дэмжихгүй, дотоод улс төрөө бид дийлэхгүй нөхцөл байдалд орох.../минут дуусав/

Х.Булгантуяа: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Боловсролын сайд П.Наранбаяраас асуулт байгаа.

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар төрийн өмнөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг боловсролын салбарын 100 мянган багш ажилтны өмнө хүлээж байгаа сайд хүн гэдгээ манай П.Наранбаяр сайд мэдэж байгаа байх.

Тэгээд 2025 оны улсын төсөвт нийт төрийн албан хаагчийн цалинг 6 хувиар нэмнэ гээд байгаа шүү дээ. Инфляцтай уялдуулж.

Тэгэхээр энэ нь өөрөө багш нарын цалин 84-хөн мянган төгрөгөөр нэмэгдэж байгаа.

Та нэг ярилцлага дээрээ өгсөн байсан. Хөдөлмөрийн яам руу тасралтгүй шаардаж шаардлага хүргүүлсээр байгаа гэсэн. Тэр шаардлагын чинь хариу ирсэн үү?

Л.Энх-Амгалан сайд руу та бас их шаардаж байгаа гэсэн ийм яриаг өөрөө өгсөн байна лээ.

Тэгээд ер нь Боловсролын яам яг хэдэн хувиар нэмэгдүүлэх санал өгсөн бэ? Үнэхээр танд нэмэх хүсэл байгаад бусад яамд тээглээд байгаа бол үүнийгээ одоо энэ Их Хурал дээрээ хэлмээр байна.

Хоёрдугаарт, үндсэн цалинг нэмэгдүүлэх олон боломжууд байгаа. Жишээ нь, гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулыг үндсэн цалиндаа шилжүүлэхэд ирэх онд багшийн цалин 1.8 сая төгрөг рүү хүрэх ийм боломж гарц гаргалгаа байна. Үүнийг тооцоолчихсон байгаа. Тэрийг та бас надтай яримаар байна. Таарахаараа тэгээд зугтаагаад байгаа юм шиг яваад байх.

Дараагийн асуулт. Та олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 3.8 сая төгрөг авч байгаа мянга гаруй багш байгаа гэсэн.

Энэ нь 1.4 сая төгрөгийн цалинтай багш 180 хувийн нэмэгдэл авч байж энэ 3.8 сая төгрөгийг чинь авна.

Тэгэхээр энэ бол яг үнэндээ боломжгүй тоо байгаа гэдгийг олон мянган багш нар чинь өөрт чинь хэлээд байна. Та ерөөсөө хүний үг авдаггүй юм уу, эсвэл ийм сонин. Энэ дээр чинь үнэхээр гайхаад байна.

2024-2025 оны хичээлийн жил эхлэхэд ерөнхий боловсролын сургууль 4200 багшийн дутагдалд орсон байгаа гээд та өөрөө ярьж байсан. Тийм ээ. Энэ дээр одоо яг хэдэн багшийн орон тоо нөхсөн бэ? Яг хэдэн багш дутуу байна вэ гэдэг мэдээллийг нийгэмд өгнө үү.

Боловсролын салбарт ажиллаж байгаа 50 гаруй мянган багш нартаа жилд ганц тохиолддог баярт мэргэжлээрээ бахархдаг энэ өдөр нь та багш нараа баярлуулах ямар сайхан мэдээг дуулгах гэж байна. Үүнийг чинь сонсмоор байна. Тийм. Баярлалаа.

Х.Булгантуяа: П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр мэдээж Ц.Мөнхтуяа гишүүн ээ, та бид хоёр чинь энэ танхимд байж байна. Би танаас ерөөсөө зугтаж байгаагүй. Яагаад зугтаж байна гэж ойлгосон юм бол доо.

Тэгэхээр би бол юуны түрүүнд өнөөдөр энэ Монголын багш нарын 58 дахь өдөр, дэлхийн багш нарын 30 дахь өдөр.

Энэ өдрийн баярын мэндийг нийт багш нартаа, боловсролын салбарт ажиллаж байгаа сайхан хүмүүстээ хүргэж байна.

Тэгээд энэ жилийн бас нэг онцлог нь “Багшийн дуу хоолойг эрхэмлэе” гэсэн урианд явж байгаа.

Өчигдөр би бас Үйлдвэрчний эвлэлийнхэнтэйгээ уулзаж, тулгамдаад байгаа асуудлуудаа ярьсан.

Багшийн дутагдлын тухайд би танд нэг жишээ хэлье. Физикийн багш гээд. Физикийн багшийн дутагдал. Одоо жишээлбэл Монгол Улсын Их Сургууль дээр физик чиглэлээр хэдэн хүн төгсгөөд байна гэхээр 2024 он гэхэд ердөө 8-хан хүн. 2022-2023 онд 2-хон хүн. 2022 онд 7-

хон хүн. Ийм байдалтай байгаа байхгүй юу.

Монгол Улсын Багшийн Их Сургуульд жилдээ 30 орчим, 40 орчим хүнийг төгсгөж байна. Физикийн багшаар.

Ингээд энэ жилийн 8 сар гэхэд физикийн 190 багш сох дутчихсан.

Тэгээд 9 сарын байдлаар 11-хэн багш ажилд орсон байгаа байхгүй юу.

Тэгээд та анзаарах юм бол сумдаар ярих юм бол физикийн багшгүй. Тэгээд химийн багшгүй. Тэтгэвэрт гарчихсан математикийн багш нь 26, 27 цаг заагаад явж байгаа. Хотын захын сургуулиуд дээр физикийн багш 40 цагийн ачаалалтай явж байгаа ийм нөхцөл байдалд байгаа. Үүнийг бол та бас дурдах хэрэгтэй.

Үйлдвэрчний эвлэл яамны хооронд ноднин жил байгуулсан хамтын хэлэлцээр байгаа.

Тэр хэлэлцээрийн 3.1 дээр бид салбарынхаа, боловсролын ажилтнуудынхаа үндсэн цалинг 30 хувиас доошгүй өсгөнө гэсэн. 2026 он хүртэл шүү. Ийм гэрээгээр хүлээсэн үүрэгтэй явж байгаа. Энэ үүргээ бид биелүүлэхээр ажиллана. Ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ дээр жишээлбэл энэ жил 6 хувийн өсөлтийг Засгийн газраас инфляцтай уялдуулж гаргаж байгаа.

Гэхдээ бид бас НҮБ-ын өмнө хүлээчихсэн үүрэг байгаа шүү дээ. Тогтвортой хөгжлийн зорилгод юу гэж хэлсэн бэ гэхээр боловсролын зардлыг

ерөөсөө нийт төсвийн зарлагын 20 хувьд хүргэнэ гэсэн.

Энэ зарлагадаа л бид хүрэхийн тулд саналаа өгөөд явуулж байгаа. Энэ жилийн хувьд Та бүхэн мэдэж байгаа. Засгийн газар 14 том төсөл дээрээ анхаарлаа тавиад эрчим хүчнийхээ дутагдлаас гаръя гэсэн ийм л зорилго тавиад байгаа шүү дээ.

Засгийн газар нэг цул гэдгийг Шадар сайд хэлээд байгаа. Бид Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын ямаар дамжуулаад энэ бодлогыг цогцоор нь шийдвэрлэхээр ажиллаж байна.

Эрүүл мэнд, боловсролын салбар дахь багш ажилтны цалин хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг хүн болгон ойлгож байгаа шүү дээ. Хүн болгон ойлгож байгаа.

Тэр тооны тухайд яамнаас бид бүр албан ёсоор.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ц.Мөнхтуяа гишүүн нэмж тодруулах уу? Тэгвэл П.Наранбаяр сайд нэмж 1 минут.

П.Наранбаяр: Багшийн цалингийн асуудал. Би Улсын Их Хурлын чуулган дээр яг хариуцлагатайгаар хэлэхэд ингэж авч байгаа миний хэлсэн тэр тоо болгон чинь ардаа баталгаатай, нотолгоотой зүйл шүү.

Өнөөдөр суманд очоод багшлахад 40 хувийг орон нутгийн нэмэгдлийг авч эхэлж байгаа шүү дээ. Зэргийнхээ нэмэгдлийг авахаар 30 хувь хүртэл байж байгаа.

Түүнээс дээшээ гүйцэтгэлийн үнэлгээ гээд явж байгаа. Гүйцэтгэлийн

үнэлгээг үндсэн цалинд нь шингээх асуудлыг та ярьдаг. Болбол тэгмээр байна. Гэхдээ энэ чинь гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан ийм цалингийн систем рүү орчхоод байгаа.

Харин гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшууллаа авч байгаа багш нарын тоог бид эрс нэмж байгаа шүү. Эрс нэмж байгаа. Үүнийг та бас ойлгож хандах ёстой шүү гэж хэлмээр байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан.

Б.Жаргалан: Шинэ парламентын анхны намрын чуулган эхлээд явж байна.

Тэгээд бид анхныхаа төсвийг батлах гээд хэлэлцүүлгүүдээ эхлээд төсвийн хүрээний мэдэгдлээ хэлэлцэж байна.

Тэгэхээр өчигдрийн чуулган дахь уур амьсгалыг харахад олонхын бүлгийн гишүүд Ардчилсан намаас томилогдоод ажиллаж байгаа сайд нар луу дайрсан, өөрсдийнхөө өнгөрсөн 8 жилийн хугацаанд хийсэн алдаа дутагдлыг томилогдоод 2 сар гаруй болж байгаа нөхдүүдээс нэхсэн ийм бас хурган попорсон тийм уур амьсгалтай хурал боллоо.

Тэгээд юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр Монгол Ардын намын дарга Ардчилсан намд урилга өгсний дагуу бид хамтарсан Засгийн газарт орсон.

Бид хамтрах эсэх тал дээр маш нухацтай хоорондоо дотооддоо ярилцаж байгаад үнэхээр

► дахиад 4 жил алдмааргүй байна,

▶ эдийн засгийг өөд нь татах хэрэгтэй байна,

▶ иргэдийн амьдралыг сайжруулах хэрэгтэй байна,

▶ томоохон төслүүдээ явуулах хэрэгтэй байна,

▶ эдийн засгаа тэлэх хэрэгтэй байна

гэсний үндсэн дээр энэ хамтарсан Засгийн газарт ороод ажиллаж байгаа.

Тийм ч учраас ерөнхийдөө эдийн засгийн хүрээний бүх ачааллууд нь манай сайд нар дээр ирж байна.

Сүүлийн хэд хоног ер нь шинэ парламент байгуулагдсанаас хойш эдийн засагтай холбоотой бүх асуудлууд дээр жишээлбэл Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр хамаг ачааллыг аваад одоо энэ бүх зүйлүүдийг тайлбарлаад таниулаад, эдийн засгаа тэлэх ач холбогдлын талаар яриад байж байгаа.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан гэхэд л одоо энэ **“Mining Week”** гээд гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарыг татах хэдэн төслүүдээ бас босгож ирэх энэ асуудлыг хөөцөлдөөд явж байна.

С.Одонтуяа сайд Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн сайд гээд бас энэ усны асуудлыг шийдэх, одоо энэ цөлжилттэй тэмцэх энэ тэр гээд л ийм асуудлууд дээр анхаараад явж байна.

Тэгэхээр эдийн засгийн асуудал дээрээ бид үнэхээр энэ улс орны эдийн засгийг өөд нь татах нь чухал гэж үзсэн учраас хамтраад явж байгаа шүү гэдгийг

өчигдрөөс хойш үг хэлээд байгаа Монгол Ардын намын гишүүд бас ойлгоосой.

Тэгээд сая ээлжит бус дээр ч гэсэндээ та нарын хэлэлцэж чадаагүй байсан гүйцэтгэлийг бид хэлэлцэж байх үед өмнө нь өөрөө сайд байсан нөхөр томилогдоод хэдхэн хонож байгаа манай сайдаас хүртэл гүйцэтгэлээ нэхээд байсан шүү.

Тэгэхээр ийм байдлаар цаашдаа хамтраад явна гэдэг бол бас асуудалтай санагдаж байна.

Тэгээд хамтарчихсан юм чинь Ардчилсан намын бүлэг хамаагүй гэсэн байдалтайгаар Ерөнхий сайд нь яахаараа төсөв хэлэлцэж байхад орж ирдэггүй юм бэ?

Яахаараа танхимд чинь ийм цөөхөн гишүүд сууж байгаа юм бэ?

Хэдүүлээ үнэхээр энэ улсынхаа хөгжлийн төлөвлөгөөг ул суурьтай хэлэлцээд ойлголтуудаа нэгтгээд явах нь зөв юм биш шүү гэсэн ийм байр суурьтай байна.

Тэгэхээр цааш цаашдын төсвийн хэлэлцүүлэг дээр Их Хурлынхаа гишүүдийн ирц дээр анхаараад, сайд нар бол кабинетаараа бүрэн бүрэлдэхүүнээрээ Ерөнхий сайд нь бас байгаад ингээд явмаар байна.

Ардчилсан нам хамтарлаа хамтарлаа гээд бид хэзээ ч микрофоноо үдүүлэхгүй гэдэг шиг үг хэлээ үдүүлэхгүй юм.

Тэгэхээр тэрийг та нар ойлгооч ээ гэж хэлэх байна.

Тэгээд энэ макро эдийн засгийн асуудлууд дээр үнэхээр ярих зүйлүүд маш их байна.

Мэдээж бид эдийн засгаа тэлэхийг зорьж байна. Гэлээ гэхдээ ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг 8 хувиар авч үзээд байна гэдэг дээр бид бүгдээрээ санаа зовоод байна.

Олон улсын байгууллагууд 6 хувь орчим гэсэн тийм тоо гаргаад байгаа гэдгийг манайхан бас хэлээд байна. Тэр дундаа хөдөө аж ахуйн салбар чинь сая хасах гарсан.

Тэгээд хөдөө аж ахуйн салбарын өсөлт ямар байхаар байна вэ гэдэг дээр би төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдээс асуумаар байна.

Ер нь энэ салбаруудынхаа өсөлтийг бас.../минут дуусав/

Х.Булгантуяа: Б.Жаргалан гишүүн санал хэллээ. Тийм ээ. Асуулт асуух гэхээсээ илүүтэй.

Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Л.Энх-Амгалан: Гишүүний гишүүний асуултад хариулья.

Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан.

Олон улсын байгууллагууд болон Монголбанк, Эдийн засаг, хөгжлийн яам ялгаатай төсөөллүүд хийж байгаа гэж байгаа.

Ер нь олон улсын байгууллагууд өмнө нь манай улсын эдийн засгийг

таамаглахдаа 5-аас 6 хувьтай л гэж хэлдэг байсан. Энэ жил харин ч 6-аас 7 хувьтай гэж хэлээд байна.

Монголбанк дээд тал нь 6 хувьтай байсан гэж таамагладаг байсан бол энэ жил 7.3 хувь гэж хэлсэн. Монголбанк таамаглалаа хийхдээ интервалаар хэлсэн байгаа. Дээд тал нь 9.2 хувь хүртэл үүсэх боломжтой гэсэн таамаглалыг бас тайландаа хэлсэн.

Тэгэхээр дараа жилийн тухайд өсөлтийн боломж үнэхээр өндөр байгаа.

Тийм болохоор л олон улсын байгууллагууд ч, Монголбанк ч, Эдийн засаг, хөгжлийн яам ч бүгд өндөр өсөлтийг хэлээд байгаа.

Засгийн газрын тухайд 8 хувь гэж хэлсний цаана Оюу Толгойн агууламж нэмэгдэж байгаа. Нүүрсний экспорт цаашаа нэмэгдэнэ. Бас аялал жуулчлал, үйлчилгээний салбарууд сэргэнэ гэсэн ийм хүлээлтийн үндсэн дээр бид таамаглалаа өндөр хэлж байгаа.

Таамаглалын зөрүү гараад байдаг асуудал бол үнэхээр 80 сая тонн нүүрс экспортолж чадах уу, чадахгүй юу гэдэг дээр л ялгаатай тоонууд авчхаад л ялгаатай төсөөллүүд яваад байдаг байгаа гэдгийг хэлье.

Хөдөө аж ахуйн салбар сая 2 жил дараалаад унасан. Дараа жил бодит өсөлт нь 6-аас 7 хувьтай байх болов уу гэсэн таамаглал байгаа.

Жуулчдын тоо цаашаа 10-аас 20 хувиар нэмэгдээд явбал үйлчилгээний салбар үргэлжлэн өснө гэсэн тийм таамаглалтай.

Уул уурхайн салбар гол нөлөөгөө бүрдүүлнэ. 14 мега төслийн 5-аас 6 нь ирэх жил хэрэгжээд эхэлнэ. Бодитоороо.

Үүнтэй холбоотой 2 нэгж хувийн нэмэгдэл өсөлт бидний тооцоонд байгаа гэдгийг бас хэлье.

Х.Булгантуяа: Б.Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Энэ салбаруудын өсөлттэй холбоотой бас нэг зүйл хэлэхэд сая Э.Батшугар гишүүн ярьж байсан.

Яах вэ, бид уул уурхайн салбар яалт ч үгүй хамаг мөнгийг оруулж ирээд байна. Бид ерөөсөө л нүүрсний мөнгөн дээр найрлаад байна гэж маш олон жил олон удаа ярьж байна. Гэлээ гэхдээ бид юуг мартаж болохгүй вэ гэхээр нөгөө тоон дээр харагдахгүй байгаад байгаа, нөгөө макро эдийн засгийн үзүүлэлтүүд дээр тод томруунаар байхгүй байгаа тэр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нар, мөн тэр хөдөө аж ахуйн салбар чинь дийлэнх ажлын байрыг бий болгож байгаа, дийлэнх айл өрхүүдийн амьжиргааг залгуулж байгаа гэдгийг ерөөсөө ор тас мартаж болохгүй.

Тэгэхээр энэ дээр бид Их Хурал дээр суучаад мега төсөл яриад байгаа хэрнээ одоо яг тэр жижиг, дунд аж ахуй эрхлэгчдийг хэрхэн яаж дэмжих юм, хөдөө аж ахуйн салбараа хэрхэн яаж босгож ирэх юм гэдэг асуудлуудаа ярихгүй байж болохгүй шүү гэдгийг дахин сануулахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо хэдүүлээ төсвийн хүрээний мэдэгдэл гээд 9 тооны хүрээнд л хязгааруудаа л ерөнхийдөө ярьж байгаа.

Энэ хязгаарын хүрээнд Засгийн газрыг төсвөө боловсруулж оруулж ирж Улсын Их Хуралд хэлэлцүүл гэсэн ийм хязгаарын тоонуудыг бүгдээрээ хэлэлцэж баталж байгаа.

Тэгээд зарим нэг деталиудыг, зарим нь Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэлэлцэж байхад асууж болохоор асуултууд нэлээдгүй гарч байх шиг байна. Зарим нь төсөв хэлэлцээд явахад гишүүд Та бүхэн салбарын сайд нараас нарийвчлаад нэмээд асуугаарай гэж хүсэж байна. Асуулт асууж дууслаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой үг хэллэгээр намын бүлгүүдээс, Ардчилсан намын бүлгээс Б.Түвшин гишүүний нэрийг ирүүлсэн байна. Б.Түвшин гишүүний микрофоныг өгье.

Б.Түвшин: Тэгэхээр энэ удаагийн орж ирсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллийн тухай хуулийг бүхэлд нь ингээд харахаар өмнө нь батлагдсанаасаа төсвийн тэнцвэржүүлсэн орлого 4.4 их наядаар, төсвийн нийт зарлагын хэмжээ 4.5 их наядаар буюу ер нь урьд түүхэнд байгаагүй их хэмжээний төсвийн орлого, зарлагын тэлэлтийг хийжээ. Хийхээр орж ирсэн байна.

Төсвийн алдагдал 1.9 их наяд байхаар ингэж тооцоолсон байгаа юм.

Яах вэ, ер нь гурван намын хамтарсан Засгийн газраар хийж байгаа эрчим хүч, бусад аж үйлдвэржилтийг сэргээх гэдэг тэр томоохон төлөвлөгөө, зорилтуудыг бодлогын хувьд дэмжиж байгаа.

Энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн том зургаараа харахад ямар эрсдэл байна вэ гэхээр ерөөсөө зарлагын энэ том тоогоо оруулж ирэхийн тулд орлогоо өсгөсөн ийм хардалт төрөөд байгаа юм.

Үүнийг нь ч гэсэн тэр Монголбанкны гаргасан тооцооллууд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүд, аудит дээр гаргасан дүгнэлтүүдээр дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт дотоодын нийт бүтээгдэхүүн нь өөрөө бас нэлээн хийсвэр дүн шинжилгээн дээр хийсэн. Бодитой гэж үзэхэд эрсдэлтэй байна гэж байгаа юм.

Нөгөөтээгүүр жилдээ 83 сая тонн нүүрс экспортолно гэж орж ирж байгаа. Зорилгын хувьд сайн.

Гэхдээ орлого хүрэхгүй болох юм бол энэ их том зарлагууд, энэ их том зээлүүд ороод ирчихсэн тохиолдолд Монгол Улсын эдийн засаг нэлээн хүндрэх байдалтай. Ялангуяа төрийн оролцоо дотоодын нутаг дэвсгэрийн 37.7 хувь руу хүрчхээр хэт их төвлөрсөн болж харагдаж байна.

Тийм учраас энэ төсвийн хүрээний мэдэгдлийг өмнө нь байснаар буюу ялангуяа гадаад, дотоод орчин ээдрээтэй байгаа тохиолдолд орлогыг бууруулах, орлогыг арай жаахан даруухнаар өөдрөг бусаар тооцоолох, зардлыг бас их болгоомжтой хийх хэрэгтэй.

Эрчим хүчний зэрэг төслүүдээс гадна ялангуяа Улаанбаатар хотын түгжрэлийг сааруулах 4 их наядын тухай яригдаж байгаа. Улаанбаатар хотын түгжрэл бол Улаанбаатар бусад

газруудаас үйлдвэр хөгжих, хүн амьдрахад дэд бүтцийн хувьд сайн байгаа учраас л төвлөрөөд байгаа гэж үзэж байгаа.

Тийм учраас үйлдвэрүүдийг гаргах. Ялангуяа арьс шир, ноос ноолуур, аж үйлдвэрүүдийг энэ бүсчилсэн хөгжлийнхөө төвүүд рүү гаргах бодлогуудыг хийгээд, энэ зам, гүүр барих асуудлуудаа түр хойшлуулбал яасан юм бэ гэж байгаа юм.

Энэ зам, гүүр барих асуудал чинь нэг талаасаа өнөөдөр богино хугацаанд төвлөрлийг сааруулж байгаа юм шиг боловч урт хугацаандаа дахиад их төвлөрлийг нэмэгдүүлэх үр дагавартай болно.

Энэ их зам, гүүрийг барих тусам, дэд бүтцийг энэ хотод сайжруулах тусам бусдаасаа илүү дэд бүтэцтэй болох учраас хүссэн хүсээгүй төвлөрөл улам нэмэгдэнэ.

Ер нь зам, гүүр барьсаар байгаад төвлөрлөө сааруулсан улс байхгүй шүү дээ. Харин барьсаар байгаад улам бетонон ширэнгэ л болчхож байгаа.

Тийм учраас үйлдвэрийн дэд бүтцүүдээ орон нутаг руу гаргаач ээ. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр яг энэ орлого, зардлыг хооронд нь уяхгүй бол зардал нь түрүүлж гарч явчхаад орлого нь дараа нь орж ирэхээ байгаад төлөвлөгөө нь биелэхээ байгаад эдийн засаг, төсөв санхүүгийн хувьд бид эрсдэлтэй байдал руу орж байгаа гэдгийг анхаарч дахин нэг хараач ээ гэдэг ийм үгийг хэлэх байна.

Х.Булгантуяа: Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр

суурьтай намын бүлгийг төлөөлж үг хэллээ.

Нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэх зөвшөөрлийн дагуу Б.Түвшин гишүүн үг хэллээ. Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлбэ.

Д.Амарбаясгалан: Манай энэ системтэй холбоотой нэг асуудал байгаа юм. Одоо тэгээд нөгөө ажлын хэсэг яасан. Ирцэд хүн шинээр орох, ирцээс гарахаар 2 минут өөр үйлдэл хийж болдоггүй. Гацчихаж.

Тэгээд одоо бүр энэ асуудал дээр Б.Пүрэвдорж гишүүн Улсын Их Хурлын дэд даргын хувьд ахлаад ажлын хэсэг байгуулаад богино хугацаанд аудит хийх шаардлага үүссэн.

Сая би орж ирээд л хурал удирдах болоод л, Х.Булгантуяа дарга эндээс

ирцээс гарангуут систем 2 минут хүлээ гээд ингээд суучхаж байгаа юм.

Ингээд ирцийн санал хураалт явуулах уу? Ирц бүртгэлийн нэг санал хураалт явуулаад үзье. Хэдэн гишүүн танхимд байна вэ? Санал хураалт. 55 гишүүн бүртгэлтэй байна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

55 гишүүн буюу 67.9 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх нь үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Дараагийн асуудалд оръё.

Гурав. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн

даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай

хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монголчууд аа,

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монголын ард иргэд шилжилтийн хэмээх тодотголтой өнгөрсөн 30 жилийг цэглэхийг хүсэж төлөвшсөн ардчиллын хоёр дахь давлагаа болсон парламентын засаглалын шинэ эрин үеийг эхлүүлэхийн тулд 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурлыг сонгуулийн холимог тогтолцоогоор бүрдүүлэх эрх зүйн цогц реформыг дэмжсэн билээ.

Нэг үгээр хэлбэл зөвхөн нутаг тойргийн биш улс орны хөгжлийн томоохон асуудлыг шийдвэрлэж чаддаг ажил хэрэгч төлөөллийг хүссэн нь судалгааны үр дүнгүүдээс тодорхой харагдаж байна.

Энэхүү өндөр хүлээлт хамт бас хариуцлагыг дагуулдаг жамтай.

Хэрэв 126 төлөөлөл бүхий энэ парламент, түүнээс бүрдсэн Засгийн газар иргэдийн энэхүү хүлээлтийг биелүүлж чадахгүй өмнөх шиг, эсвэл бүр өмнөхөөсөө тааруу гэсэн нийгмийн дүгнэлтэд хүрвэл ардчилсан парламентын засаглалд аюул учрах хэмжээний эрсдэл өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд үүл мэт хуралдсан

та бид хамтдаа бүрэн ухамсарлах учиртай.

Аливаа асуудлын шийдлийг олж, амжилт бүтээхэд нөр их хөдөлмөр хичээл зүтгэл хэрэгтэй ч нураахад нэг л бодлогогүй үйлдэл хангалттай байдгийг бид 2014 оноос хойш 10 гаруй жил зарцуулж байж ахиулсан зээлжих зэрэглэлийн үнэлгээнээс бэлээнэ харж, бас суралцаж болно.

Ийм л алдааг давтахгүйн тулд бид хамтарсан Засгийн газрыг байгуулж “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээнд үндэслэн Засгийн газар эхний төсвөө Улсын Их Хуралд ийнхүү өргөн барьж байна.

2025 оны төсөв бол Монгол Улсын хувьд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу боловсруулсан эхний төсөв бөгөөд ирэх 4 жилийн улс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох талаасаа түүхэн ач холбогдолтой төсөв гэж үзэж болно.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын төсөв бол Монгол хэмээх айлын зөвхөн орлого, зарлагын төсөөлөл төдийгүй улс орны эдийн засгийн багтаамж, дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний нийт орлогыг чиглүүлэн сэдэлжүүлэх суурь байдаг онцлогтой.

Аль ч улс орны эдийн засгийн хөгжлийг дотоодын нийт бүтээгдэхүүнээр л хэмждэг. Бид ч олон улсын энэ жишгээр хөгжлийн суурь үзүүлэлтээ одоо ч, цаашид ч хэмжих нь ойлгомжтой.

Монгол Улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4 мянга орчим ам.долларт сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд гацсаны эцэст боомтын нэвтрэх хүчин чадал сайжирч, эрдэс баялгийн салбарын далд эдийн засаг ил болж, аялал жуулчлалаас олох орлого нэмэгдсэнээр 2023 онд 6 мянган ам.доллар давсан бол энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүн 79.2 их наяд төгрөгт хүрч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 6800 орчим ам.долларт хүрэхээр төсөөлөгдөж байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2025 онд 3.3 орчим хувьтай байхаар байна.

Харин манай бүс нутгийн хэмжээнд эдийн засаг 5.1 орчим хувийн өсөлттэй байхаар олон улсын байгууллагууд төсөөлж байна.

Мэдээж өдрөөс өдөрт дэлхий улам хуваагдмал болж байна.

Мөн хурдтай хувьсан өөрчлөгдөж буй олон улсын геополитикийн нөхцөл байдал эдийн засагт том хэмжээний эрсдэлийг дагуулах нь тодорхой.

Монгол Улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг Дэлхийн банк 4.8 орчим хувь, Олон Улсын Валютын Сан 4.1 хувь гэж тооцож байсан бол зээлжих зэрэглэл “В тогтвортой” түвшинд хүрч, өнөөдөр бас зээлжих зэрэглэлийн нэг дүн дахиж зарлагдах гэж байгаа юм байна. S&P үдээс хойш тодорхой болох байх. Мөн зээлжих зэрэглэл өсөж байгаа.

Энэ агуулгуудаар нэг хүнд ногдох үндэсний орлогоор Дэлхийн банкны ангиллаас дунджаар дээгүүр ангилалд шилжүүлсэнтэй холбогдож, мөн хамтарсан Засгийн газар байгуулагдсантай холбогдуулж томоохон төслүүдийг хөдөлгөхөөр зарлагдсантай уялдуулан төсөөллөө 5-аас 6 хувь болгон, магадгүй түүнээс дээш хувь байхаар төсөөллөө шинэчилж байна.

Мөн энэхүү төсвийн хэлэлцүүлгийг олон улсын байгууллагууд болон хөрөнгө оруулагчид анхааралтай ажиглан харж байна.

Мэдээж бид эрсдэлийг тооцох учиртай.

Эрхэм гишүүдийн чуулганд хэлсэн өчигдрийн үгүүдийг ч би бүтэн сонссон.

Гэхдээ бид хамтарсан засгийн газрыг байгуулсан шалтгаан нь зориг гарган хөгжлийг урагшлуулах л зорилгыг тавьсан.

Хэрвээ бид энэ эрсдэлтэй гэдэг агуулгаар бүх зүйлийг хойш нь тавиад байвал байгаа байрандаа л байсаар байх болно гэсэн үг.

Тийм ч учраас Засгийн газар хэрэгжүүлэх 14 мега төслийн 5-аас доошгүй төсөл 2025 оны төсвийн жил эхэлж чадвал 2025 оны эцэст дотоодын нийт бүтээгдэхүүн 95 их наяд төгрөгт хүрнэ гэж өөдрөгөөр төсөөлөв.

Хэрэв 2026 онд багтаж энэхүү 14 мега төслөө бүтэн хөдөлгөж чадвал 2028 он гэхэд дотоодын нийт

бүтээгдэхүүн 132.3 их наяд төгрөгт хүрч нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянган ам.долларт хүрэх бодит боломж байна гэж Засгийн газар үзэж байна.

Яагаад бид нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянган амдоллар, түүнээс цааш гэж олон жил ярив. Энэ түвшинд Монгол Улс хэзээ ч хүрч үзээгүй.

Гэвч хүрсэн улс орнуудын хувьд дараах эерэг өөрчлөлтүүд гарсан байдаг нь судлаачид тогтоосон байдаг.

Хэрвээ дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянган ам.доллар болон түүнээс дээш болсон тохиолдолд зээлжих зэрэглэл өнөөдөр байгаагаас 1-ээс 2 түвшин дээшилж зээлийн хүү 30 хүртэл хувь буурах боломжтой болно.

Гадаадын хөрөнгө оруулалт 1.5-аас 3 дахин өсөж, дэд бүтцийн асуудал бүтэн шийдвэрлэгдэнэ.

Шинжлэх ухаан, технологид оруулах хөрөнгө оруулалтын хувь нэмэгдэж, үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдсэнээр эдийн засаг төрөлжих суурь тавигдана.

Чадварлаг хүний нөөц эх орондоо буцан ирж, гадаадын чадварлаг мэргэжилтнүүд тус улсад ажиллаж эхэлнэ.

Иргэдийн дундаж цалин 60 хүртэл хувь өсөж, өрхийн орлого нэмэгдсэнээр ядуурлын түвшин буурч, төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнээр засаглалын бүтээмж сайжирдаг.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжил сайжирч, чанартай үйлчилгээ авснаар иргэдийн амьдралын чанарт нөлөөлж, хүн амын дундаж наслалт нэмэгддэг зэрэг эерэг үзүүлэлтүүд гардаг.

Дэлхий дээр хөгжлийн өөр ид шид, жор огт байхгүй. Гагцхүү бид тууштай алхам алхмаар эдийн засгаа тэлж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ аль болох ойрын хугацаанд 10 мянган ам.доллар түүнээс дээш гаргах учиртай.

Хэдийгээр бид шүүмжлэл ярьж байгаа ч сүүлийн 3 жилийн дотор нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг жил бүр мянган ам.доллараар өсгөж чадсан.

Хүн төрөлхтний амьдралын хэв маяг асар хурдацтай өөрчлөгдөж байгаа энэ цаг үед хиймэл оюун ухааны эрчимтэй хөгжлийн энэ үед монголчууд бид хөгжлийг хөөж биш харин угтаж түрүүлэхтэй л уялдуулан аливаа асуудлыг бид хурдтай бас зоригтой шийдвэрлэх ёстой.

Өнгөрсөнтэйгөө зууралдах бус илүү алсыг харж, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж хурдтай хөгжих зоригтой шийдлүүдийг хамтдаа гаргах нь зүйтэй.

Монгол Улс хурдтай хөгжлийн төлөө эдийн засгийн 14 мега төслийг дараах эрэмбээр 2025 онд Улсын Их Хуралд танилцуулж ил тод хамтдаа хэлэлцэн шийдвэрлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

Яагаад 14 мега төсөл гэж онцолж байгаа гэвэл гагцхүү энэ 14 мега төсөл

дотоодын нийт бүтээгдэхүүнийг тэлж тэр тэлсэн санхүүжилтээр бид бусад асуудлаа шийдэх учраас үүнийг ярьж байгаа юм.

14 мега төслийн нэгдүгээрт хэлэлцээрийн шатанд 18 жилийн хугацаанд гацсан Гашуунсухайт-Ганцмод хилийн хил дамнасан холболтын ажлыг дуусгах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Энэ хил холболтыг дуусгаж чадсанаар бид экспортын хүчин чадлыг 2 дахин нэмж, нүүрс тээврийг 20 сая тонн, мөн Хангимандал-Шивээхүрэн боомттой уялдуулж 40 сая тонноор нэмэгдүүлэх боломжтой.

Энэ тохиолдолд жил бүхэн бид 1.5 тэрбум доллар. Ханги, Шивээхүрэн оролцуулж чадвал дахин 1 тэрбум долларын орлогыг олох боломжтой.

Орлого өсөх болгонд төсөв тэлдэг нь дэлхийн жишиг.

Тийм учраас бид экспорт дээрээ л бүгдийг зориулах учиртай.

Хоёрдугаарт, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийн бүтээн байгуулалтыг бид 2025 оны төсвийн жилд багтаж зайлшгүй эхлүүлэх шаардлагатай.

Мэдээж энэ асуудал дээр олон асуудлууд байгаа. Орон нутгийн улс төржилт зэрэг олон асуудал. Мөн байгаль хамгаалал зэрэг олон асуудлын зарим нэг асуудлыг Улсын Их Хурлын дэмжлэгтэйгээр Засгийн газар шийдвэрлэнэ.

Энэ станцыг бидний хувьд шийдэж чадвал 2027 оноос эхлэн баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах боломжтой юм.

26 жилийн туршид хайгуулын үйл ажиллагаа явуулсан Монгол, Францын хамтарсан ураны төслийг мөн гуравдугаарт эрэмбэлэн бид Улсын Их Хуралд оруулж ирэх болно.

Энэ төслийг хөдөлгөж чадвал Оюу Толгойгоос хойш гурав дахь хөрш оронтой Монгол Улсын Засгийн газар хэлцэл хийж буй хөрөнгө оруулалтын хоёр дахь гэрээ болно.

Мэдээж Оюу Толгойн гэрээн дээр гарсан 34 хувь байх эсэх болон байгаль хамгаалалтай холбоотой зарим асуудлууд байгаа. Гэхдээ л бид ил тод энэ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх нь хөрөнгө оруулагчдад эерэг ойлголтыг өгсөн томоохон алхам болж чадна.

Засгийн газраас дараа нь уур амьсгалын өөрчлөлт, ногоон шилжилт, мөн говийн бүс нутагтай холбогдуулан Орхон-Онги, Хэрлэн-Тооно ус дамжуулах хоолойн аль нэг болон бусад техник, эдийн засгийн үндэслэлийг төлөвлөж говийн бүсэд хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг гадаргын усаар хангах нөхцөл бүрдүүлж, Улаан нуурыг сэргээх, нуур орчмын эко систем, биологийн олон янз байдал сэргэж, цөлжилтийг бууруулах зэрэг ач холбогдолтой говийн бүс нутгийг усжуулах төслийг эрэмбэлж байгаа.

Говийн бүс нутгийг усжуулах төслийг хэрхэн санхүүжүүлэх, эрдэс баялаг болон бусад боломжтой хэрхэн

уялдуулах талаар мөн Их Хурал дээр бид нээлттэй ярилцах болно

2013 оноос эхлэн хэлэлцээрийн шатад 10 гаруй жил гацсан Тавантолгойн 450 мегаваттын дулааны станцын төслийг мөн бид Их Хуралтай хамтарч зарим эрх зүйн орчныг өөрчлөн хийх шаардлагатай байгаа.

Оюу Толгойн хэлэлцээр, мөн Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдолтой өмнөд бүс нутгийн уул уурхайн төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос бүрэн хангах боломжтой энэ төсөл хэрэгжсэнээр говийн бүс нутаг болон бидний хэрэгжүүлж байгаа 14 мега төсөл дээр ихээхэн түлхэц болох боломжтой гэж үзнэ.

Монгол орны хаанаас ч интернэттэй холбогдох мэдээллийн технологийн үйлчилгээ авах боломжтой Үндэсний хиймэл дагуулын төслийг зөөлөн дэд бүтэц болон цахим технологийн шинэчлэлийн хүрээнд бид явуулах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Мэдээж энэ дээр мэргэжлийн боловсон хүчнүүдтэй ярилцах, Их Хурал дээр ярилцах олон асуудлууд байгаа.

Түүнчлэн боловсруулах үйлдвэрийн багц төслүүд. 3-аас 4 төсөл байгаа. Та бүхэн мэдэж байгаа. Сэргээгдэх эрчим хүчний багц төслүүд. Мөн 3-аас 4 төсөл байгаа.

Мөн Нийслэлийн дэд бүтцийн багц төслүүдийг Улсын Их Хуралд танилцуулж та бид хамтын шийдэл гаргах болно.

Эхлээд хот, эсвэл хөдөө, эсвэл эхлээд хөдөө, эсвэл хот хөгжиж байж түгжрэл шийдэгдэнэ гэж бид бодож болохгүй. Бид аливаа асуудлыг хамтад нь цаг алдалгүй л шийдэх учиртай.

Яагаад гэвэл бид түгжрэлд маш их хэмжээний цагийг алдаж байна.

Дахин хэлэхэд эдгээр 14 төслийн 5-аас доошгүй нь хэрэгжиж эхэлснээр 2024 оны төсвийн жилийн төлбөрийн тэнцэл болон валютын нөөцийн эрсдэлгүй байх болно.

Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, лиценз олголтын асуудлыг ил тод болгох, боловсруулах үйлдвэрийг татварын орчноор дэмжихээс гадна хөдөө аж ахуй, аялал жуулчлал, эрчим хүчний салбарыг онцгой анхаарч эдийн засгийг төрөлжүүлэх зардлуудыг 2025 оны төсөвт мөн суулгалаа.

Хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил, бизнесийн орчныг дэмжих байдлаар үндэсний битүүмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, худалдан авах ажиллагааны тухай, татвар, төсвийн зарлагын шинэчлэл, Үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглал, үндэсний орон сууцжуулалтын тогтолцоо, хуримтлалын сан, бүсчилсэн хөгжил, Улаанбаатар хотын бүтээн байгуулалт ба дагуул хот, хотын засаглал, эрчим хүчний салбарын шинэчлэл, ногоон эдийн засаг ба ногоон шилжилт, их өгөгдөл хиймэл оюун ухаанд суурилсан цахим шилжилт, төрийн албаны эрх зүйн шинэчлэл, үндэсний сөрөн төсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх эрсдэлийн удирдлага, уул уурхайн тусгай зөвшөөрлийн олголт, ашиглалт,

эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зэрэг 14 багц эрх зүйн реформыг 2025 оны төсвийн жилд багтаан боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөж байна.

Эдгээр эрх зүйн суурь реформыг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байгаад Улсын Их Хурлын дарга Дашзэвэгийн Амарбаясгалан болон ажлын хэсгийн эрхэм гишүүдэд талархал илэрхийлье.

Засгийн газар энэхүү эрх зүйн цогц реформ дээр бүх талаар дэмжиж, гар нийлж, хамтран ажиллахаа мөн илэрхийлье.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Та бид хамтдаа энэ бүрэн эрхийн хүрээнд тавьсан зорилгодоо хүрэхийн тулд 2025 оны төсвийг эдийн засгийн суурь бүтцийг тэлэх дэд бүтцэд зарцуулах шаардлагатай.

Төсвийг жил бүхэн тэгшитгэн хуваадаг тогтсон хандлагаас зориг гарган хамтдаа салцгаая.

Энэ агуулгаар Монгол Улс өмнө нь төсвийн жилд дунджаар 450-иас 500 орчим шинэ төслүүдийг эхлүүлдэг байсан.

Мөн 600-аас 800 орчим шилжих төслийг санхүүжүүлдэг байсан. Тийм бол 2025 оны төсвийн төсөлд ердөө 38 дэд бүтцийн шинэ төслийг санхүүжүүлэхээр тусгалаа.

Энэ бол Та бүхний өчигдрийн ярьсан зардлын реформ юм.

Монгол Улс Мянганы замын их бүтээн байгуулалтын хүрээнд 7 мянга гаруй километр авто замыг тавихад 21 жилийг зарцуулсан.

Тийм бол бүсчилсэн хөгжлийн суурийг тавихад чиглэсэн аймгийн төвүүдийг хооронд нь хилийн боомтуудтай эдийн засгийн ач холбогдлыг дарааллаар нь холбох замыг бий болгохын тулд бид ирэх 4 жилийн хугацаанд 4400 километр орчим авто замыг шинээр барьж, ирэх оны төсөвт 2100 орчим километр авто замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Зам дагаж хөгжил гэж ярьдаг. Төрөлжсөн болон дэд бүсүүдийг дэмжих хүрээнд энэ дэд бүтцийн асуудлуудыг шийдэхгүйгээр бид эдийн засгаа тэлж чадахгүй.

Мөн төрөлжсөн болон дэд бүсүүдийг дэмжих хүрээнд 1650 мегаватт шинэ эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох, мөн цэвэр эрчим хүчний шилжилт хийх зардлыг 2025 оны төсөвт тусгалаа.

Мөн тодотголоор энэ зардлыг шийдвэрлэж өгсөнд Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье.

Мөн нийгмийн салбарын хөрөнгө оруулалтыг бүрэн санхүүжүүлж чадаагүйгээс барилгын чанарын асуудал гарч, шилжих нэртэй олон төслүүд сунжирсан нь үнэн.

Тийм ч учраас өнгөрсөн хугацааны бүх эхэлсэн төслүүдийг буюу 602 төслийг бүрэн дуусгах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх нь хамгийн оновчтой гэж үзлээ.

Ингэснээр улсын хэмжээнд 90 сургууль, 62 цэцэрлэг, 31 эмнэлэг, 22 дотуур байр, соёл, спортын байгууламж 60, гэр бүл, нийгмийн хамгааллын 18 байгууламж бүрэн ашиглалтад орох болно.

Ингэснээр сургуулийн хүчин чадал 40 мянга 610 суудлаар, цэцэрлэгийн хүчин чадал 9 мянга 540 ороор тус тус нэмэгдэнэ.

Нийгмийн суурь үйлчилгээг иргэд, нийгмийн бүлгүүд рүү чиглүүлж, чанартай, хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг шат дараатай авч ирэх оны 01 дүгээр сараас эхлэн өндөр настны тэтгэвэр, халамжийн тэтгэвэр, төрийн албан хаагчийн цалинг инфляцтай уялдуулж 6 хувиар нэмэгдүүлэхээр тусгалаа.

Орон сууцжуулалт бол иргэдийн амьдралын баталгааны хамгийн чухал хэсэг бөгөөд нийгмийн, тэр дундаа залуучуудын, төрийн албан хаагчдын судалгаагаар эхэнд гарч байгаа нэг номерын асуудал бол орон сууцжуулалт юм.

Тийм ч учраас Засгийн газраас үндэсний орон сууцжуулалтын реформыг Үндэсний баялгийн санг Хуримтлалын сантай уялдуулан шийдэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэснээр бид нар жил бүхэн 1 их наяд төгрөгийн санхүүжилтийг орон сууцын ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэд зарцуулж, ирэх жил 13 мянга орчим иргэнийг хамруулах боломжтой болно.

Үндэсний орон сууцжуулалтын энэхүү ажлын хэсгийг Ерөнхий сайд өөрөө ахлан Их Хурлын гишүүд Та бүхэнтэй, мөн орон нутгийн удирдлагуудтай нягт хамтран ажиллана гэдгээ илэрхийлье.

Бүсчилсэн хөгжлийн реформын хүрээнд нийслэл Улаанбаатар хотод 1992-2021 оны хооронд 11.5 их наяд төгрөгийн л хөрөнгө оруулалт хийгдсэн байдаг.

Энэ бол хүн амын тал орчим хувь нь амьдран суудаг нийслэл Улаанбаатар хотод хэтэрхий хангалтгүй хөрөнгө оруулалт юм.

Тийм ч учраас бид 2028 он хүртэл хамгийн багадаа түүнээс 3 дахин их хэмжээний буюу 30-аас дээш их хэмжээний их наядын хөрөнгө оруулалтыг нийслэл Улаанбаатар хотод оруулж байж бид түгжрэл болон бусад асуудлыг шийдвэрлэнэ.

Тийм ч учраас Засгийн газраас нийслэлийн 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг энэ төсвийн жилд багтаан Улсын Их Хуралд өргөн барих болно.

Нийслэлийг Хөшгийн хөндийтэй холбосон туннел, нийслэлийн төвийг туннелтэй холбосон гүүр, Туул хурдны зам, Тэрэлжийн замын бүтээн байгуулалт, Толгойтоос Амгалан өртөө хүртэлх 17.7 километр метроны шугам зэрэг бүтээн байгуулалтын төслүүдийг 2025 оны төсвийн жилд хамтдаа зориг гарган эхлүүлцгээе.

Эдгээр хөрөнгө оруулалтыг бүтэн шийдвэрлэж чадвал олон жил ужгирсан нийслэлийн түгжрэлийн

асуудлыг бид бүрэн шийдвэрлэж чадна гэсэн үг юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас боловсруулсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэгдсэн төсвийн үзүүлэлтийг дараах байдлаар төсөөллөө.

2025 оны төсвийн нийт эх үүсвэр 35.8 их наяд төгрөг, урсгал зардал 24.5 их наяд төгрөг, хөрөнгө оруулалтын зардал 4.3 их наяд төгрөг, Тогтворжуулалтын сан 608.9 тэрбум төгрөг, Үндэсний баялгийн сан 2.4 их наяд төгрөг байхаар тооцов.

2025 оны төсвийг энэхүү төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж чадвал эдийн засгийн өсөлт 7-гоос 8 хувь болж, экспортын орлого 19 тэрбум ам.долларт хүрч, гадаад валютын нөөц 5.7 тэрбум ам.доллар болон нэмэгдэж, өрхийн бодит орлого дунджаар 15 хувиар өсөж, бизнес эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдэж, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Мөн 35 мянга орчим ажлын байр шинээр бий болно гэж тооцлоо.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төсвийн төслийн талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

Индэрт урьж байна.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал Засгийн газарт хүргүүлсэн болно.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангаж, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформ, нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилтын хүрээнд төсөвлөгдсөн байна.

Гэвч өмнөх оны төсвийн төслийн аудиторoor өгсөн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нийцсэн эсэхийг хянаж үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүй хэвээр. Нийт зөвлөмжийн хэрэгжилт 69 хувьтай байгаа юм.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурт нийцэж байгаа эсэхэд аудитаар дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

Нэг.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 42.6 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв, санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаатай нийцэж байна

Хоёр.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 864.7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35.6 хувь, нийт зарлага 35 их наяд 796.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909.5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь 1 их наяд 930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2-оос дээш хувийн ашигтай байх, нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээ нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны дүнгээр дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн тусгай шаардлагуудыг хангаж байна.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлалд нийцсэн боловч Улсын Их Хурлаас улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлаагүйгээс түүнд чиглэсэн эсэхийг харьцуулан дүгнэх боломжгүй байгаа тухайн үеийн байдлаар:

1.Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай байна.

2.Төсвийн төслийн хамт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг өргөн мэдүүлсэн нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн

төлөвлөлтийн асуудлуудыг бууруулж байна.

3. Засгийн газраас 2025 онд бүсчилсэн хөгжлийн хүрээнд дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх зорилт дэвшүүлэн авто зам, эрчим хүч, дэд бүтцийн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь өмнөх онуудад улс, бүсийн түвшинд тэргүүлэх ач холбогдол багатай олон жижиг төсөл, арга хэмжээг улсын төсвөөр санхүүжүүлэхээр тусгаж байсантай харьцуулахад төсөл, арга хэмжээний цар хүрээ, үр нөлөөний хувьд тодорхой ахиц гарсан байна.

4. Шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалд зөвхөн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг хамруулж байгаа нь бусад ангиллын төсөл, арга хэмжээг орхигдуулах, тусгай шалгуур үзүүлэлтээр үнэлээгүй, шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгах эрсдэлийг дагуулж байгаа юм.

5. Өмнө оноос шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээнээс худалдан авах ажиллагаа зарлагдаагүй, гүйцэтгэгч шалгараагүй, төсөвт өртөг нь нэмэгдсэн зэрэг шалтгаанаар нийт 1 их наяд 168.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 420.8 тэрбум төгрөгийн 130 төсөл, арга хэмжээг төсвийн төсөл тусгаагүй байна.

6. Төсөл арга хэмжээний санхүүжилтээс үргэлжлэх хугацаатай нь уялдуулахгүйгээр 3 жилд тэнцүү хуваарилахаар хуульд заасан нь олон жил үргэлжлэх томоохон барилга, байгууламжийн хувьд төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн эх

үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байх, нөгөө талаас санхүүжүүлэх шаардлагатай бусад арга хэмжээний төсөв батлагдаагүй орхигдох эрсдэлийг үүсгэж байна.

7. Цахим систем болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар, журам хангалтгүй байгаа нь төсөв өртгийг үндэслэлтэй тооцож, үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

Аудитын дүгнэлтэд үндэслэн Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд Та бүхэнд дараах асуудлуудыг толилуулж байна. Үүнд:

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг жилийн төсвийн төслийг боловсруулахаас өмнө баталж байх, Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зарчмын хүрээнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх.

Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд дараах зөвлөл дараах зөвлөмжийг өгч байна.

Монгол Улсын Засгийн газарт:

Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн чанарыг дээшлүүлж, төсвийн сахилга батыг хангаж ажиллах. Төсвийн төслийг төрийн мөнгөний бодлогод нийцүүлэх. Төсвийн зардлын тэлэлтээс нийгэм, эдийн засагт үзүүлж

болзошгүй сөрөг үр дагаврыг үнэлж бууруулах арга хэмжээ авах. Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төлөвлөлтийн болон эрх зүйн шаардлагыг хангуулах. Төсвийн боломжит эх үүсвэр бүх төрлийн ашигт малтмалд ногдуулсан АМНАТ-ыг бүрэн төвлөрүүлэх. Хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцож, төлөвлөсөн хугацаанд чанартай гүйцэтгэхэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх. Геополитикийн тогтворгүй байдлын улмаас авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөх эрсдэлтэй байгаа тул шаардлагатай стратегийн нөөц бүрдүүлэхэд анхаарч ажиллах.

Улсын хөгжлийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд бүсүүдэд, улсын хэмжээнд салбарын хөрөнгө оруулалт зэргээр байршил тодорхойгүй тусгагдсан арга хэмжээний задаргааг тусгайлан хэлэлцүүлж батлуулах.

Өмнөх онуудад хэрэгжиж эхэлсэн нь дуусаагүй боловч төсвийн төсөлд тусгаагүй төсөл, арга хэмжээний үр ашигт анхаарч холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлэх.

Сангийн яаманд:

Хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхыг нь сайжруулах.

Улсын Их Хурлаас баталсан төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн төсвийн төслийг боловсруулж байх. Төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгийг төсөвт бүрэн төвлөрүүлэх. Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал даатгалаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төрөл ангиллаар нь нарийвчлан тодорхойлж хууль журамд тусгах. Тоног төхөөрөмж их засвар болон техник, эдийн засгийн үндэслэлийг төлөвлөх, эрэмбэлэх аргачлал, зохицуулалтыг тодорхой болгох, төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүрийг журмын дагуу үнэлж эрэмбэлэх, үргэлжлэх хугацааг үндэслэлтэй төлөвлөх шаардлагатай байна.

Эдийн засаг, хөгжлийн яам.

Цахим систем нэршлээр төсвийн төсөлд тусгасан төсөл, арга хэмжээ болон техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох.

Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад төсвийн ерөнхийлөн захирагч нар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Одоо Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр танилцуулна.

Индэрт урьж байна.

Н.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга аа, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулан гаргасан дүгнэлтийг урьдчилан хүргүүлсэн байгаа.

Ингээд би энэ дүгнэлтээсээ бас цаг хожих үүднээс хураангуйлан танилцуулъя гэж бодож байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.1.5.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8.4.8 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1 дэх заалтын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дүгнэлт гаргаж Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хуульд заасан цаг хугацаанд нь хүргүүлсэн.

Зөвлөл дүгнэлт гаргахдаа өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх, 7.3-д заасан төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ гэснийг баримталсан эсэх.

Мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл 6.2.1, 6.2.2, 6.3.3, 6.4.1, 27 дугаар зүйл, 32.2-г заасны дагуу боловсруулагдсан эсэхэд анх харсан.

Томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхээр 2025 оны төсөлд ч

тусгагдсан байгаа нь чухал ач холбогдолтой гэдэгтэй Төсвийн тогтвортой байдлын зөвлөл санал нэгтэй байгаа.

Ингээд төсвийн тодорхой зүйл заалтуудын талаар санал, дүгнэлтээ танилцуулъя.

Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар:

Төсвийн орлогыг эдийн засгийн мөчлөг дагуулан өндрөөр төлөвлөж байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлого, тусламжийг өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 6.2 их наяд төгрөг буюу 20.2 хувиар өсөхөөр төлөвлөсөн байна.

Нийт орлого, тусламжийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 38.8 хувь болж, 2017-2024 онуудын дундаж болох 32.2 хувиас 5.86 нэгж хувиар, өмнөх оноос 1.3 нэгж хувиар өсөхөөр байна.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зүгээс Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг төсвийн төсвийн төсөл хэлбэрээр бүртгэснээс доогуур таамаглаж, зэсээс бусад голлох түүхий эдийн үнэ, ханш ирэх жилүүдэд буурах хандлагатай байгаа талаар мэдээлж байгаа учраас төсвийн орлогын төлөвлөлтөд онцгой анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Төсвийн зарлага төлөвлөлтийн талаар:

Эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлагын хэмжээ 2011 онд 45.1 хувь, 2012 онд 43.3, 2016 онд 39.7, 2020 онд 37.6 хувь, 2021 онд 37.1 хувь болж сүүлийн 15 жилийн дунджаас өндөр байсан бол 2024 оны тодотголын дараа 38.5 хувь, 2025 оны төслөөр 37.7 хувь байхаар байна.

Өнгөрсөн жилүүдэд эдийн засгийн өсөлт нь төсвийн орлого, зарлагын өсөлтийг гүйцээгүй нь эдийн засаг дахь төрийн үүрэг оролцоо өндөр байгааг харуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч бүр Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-д заасны дагуу төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал хийдэгдлийг арилгах, хүртээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг төсвийн бусад байгууллагад 3-аас 5 жилд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулна гэсэн заалт бүрэн хэрэгжихгүй байгаад хэрэгжилт нь хангалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд.

Хөрөнгө оруулалтын бодлого нь макро эдийн засаг, нийгмийн тэргүүлэх зорилгоор чиглэсэн байна.

Хөрөнгө оруулалтын бодлого нь чиглэлийн хувьд хөгжлийн хөрөнгө оруулалт, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийх энэ хүрээнд авто зам, эрчим хүч, дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэхээр тусгагдсан байна.

Гэвч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдэх, бизнес эрхлэх орчин, амьдралын чанарыг эрс сайжруулах гэсэн зорилгуудыг хэмжигдэхүйц үр дүнгээр илэрхийлэхгүй бол төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн тодорхой бус байж магадгүй байна.

Хэдийгээр төсвийн ерөнхийлөн захирагчид тус бүрээр хүрэх үр дүн хөтөлбөрөөр гаргаж байгаа боловч төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн баримт бичгүүдэд эдийн засаг, нийгмийн зорилгын хэрэгжилтийг хэмжих нэгдсэн үзүүлэлт байхгүй байна.

Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх шаардлага байна.

Олон Улсын Валютын Сангаас Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын менежментийн үнэлгээг 2003 онд хийж тайланг гаргасан.

Уг тайлан нь Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг доогуур байгааг анхаарч төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бодитойгоор хэмжих, дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн үр ашгийг сайжруулахын тулд хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд онцгой анхаарах шаардлагатай гэж тэмдэглэсэн байна.

Харамсалтай нь энэ тайланг одоогоор албан хэрэгцээнд ашиглахаар хязгаарласан. Олон нийтэд хүртээл болгоогүй байгаа учраас энэхүү тайланг цаашдаа олон нийтийн хүртээмж болгох шаардлагатай гэж үзэж байна.

Хөрөнгө оруулалтын төслийг сонгох, эрэмбэлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтыг үнэлж эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа нь Засгийн газар Сангийн яамны баталсан журмуудын хүрээнд одоогоор хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь тодорхой сул талтай байна.

Хөрөнгө оруулалтын төслүүдийг төлөвлөхөөс эхлээд сонгох хүртэлх үйл явц нь Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, төсвийн ерөнхийлөн захирагчдын оролцоотой хийгдэж байгаа боловч үүнд ил тод байдал, олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт дутагдаж байна.

Олон Улсын Валютын Сангаас гаргасан төсвийн хөрөнгө оруулалтын дээрх дурдсан менежментийн үнэлгээний тайланд ч энэ талаар тодорхой зөвлөмж өгсөн байгааг анхаарах ёстой.

Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц хууль эрх зүйн орчин шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж буй аливаа хуулийн төслийг боловсруулах явцдаа хэд хэдэн

судалгаа, үнэлгээ хийгдсэн байх ёстой гэсэн шаардлага тавигдаж байгаа.

Гэвч энэ хуульд жил бүрийн төсвийн тухай хууль, төсвийн тодотгол, төсвийн хүрээний мэдэгдэл хамрахгүй байгаагийн улмаас Хууль тогтоомжийн тухай хуульд дурдагдсан дээрх нэн чухал шаардлагуудыг төдийлөн хангаагүй төсөл, арга хэмжээ төсөвт тусгагдах үүд хаалга бол нээлттэй байна.

Иймээс улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн цогц орчныг бий болгохын тулд бусад улс орнуудын сайн туршлагын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулах асуудлыг Улсын Их Хурал судлан авч үзэх ёстой гэж үзэж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг оновчтой хувилбарыг тодорхойлох, аливаа төслийг урьдчилан сайтар сурталчилсны үндсэн дээр түүнийг ямар эх үүсвэрээс ямар арга замаар санхүүжүүлэх нь хамгийн оновчтой болох вэ гэдгийг тодорхойлох ёстой.

Бүхий л төслийг зөвхөн улсын төсөв, гадаад зээлээр санхүүжүүлнэ гэж төлөвлөх нь төдийлөн оновчтой арга зам биш юм.

Тиймээс цаашид аливаа мега төслүүдэд төсвийн гадаадын зээлийн санхүүжилтээс гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын холимог хэлбэрээр оруулсан холимог санхүүжилтийн арга хэлбэрийг сонгох нь оновчтой байж болох юм гэдгийг анхаарах шаардлагатай.

**Засгийн газрын өр төлбөрийн
талаар:**

Засгийн газрын өрийн үлдэгдэл жил ирэх тусам нэмэгдэж байна.

2022-2024 онуудад төсвийн хүрээний мэдэгдлээс харахад Засгийн газрын өрийн хэмжээ жил ирэх тусам нэмэгдсэн хэдий ч Засгийн газрын өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувьцаа багасаж байна.

Засгийн газрын баталгаа гаргасан бондуудын эргэн төлөлтийг хийхэд гадаад санхүүжилтийн хэрэгцээ их байгаа нь төсвийн эрсдэл гадаад хүчин зүйлд өртөх эмзэг байдал хадгалагдсаар байгааг илэрхийлж байна.

Энэхүү тайлантай хамт бидний энэ гаргаж байгаа дүгнэлт бол өнгөрсөн жилүүдэд олон улсын байгууллагаас Монгол Улсад зориулан гаргасан удаа дараагийн тайлан тусгагдсан дүгнэлтээ бодлого санааны хувьд нийцэж байгаа юм шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Энэ тайлангаас би ганцхан зүйлийг уншиж өгөхийг Та бүхэнд хүсэж байна.

Дэлхийн банкнаас гаргаж байсан 2018 оны тайланд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь ил тод байдлыг нэмэгдүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжиж, төсвийн үйл ажиллагааны талаар илүү эрүүл зөвлөмжийг гаргадаг юм.

Тиймээс энэ институцийг аль болохоор бие даасан хараат бус байлгаарай гэсэн ийм зөвлөмжийг өгч байсан гэдгийг дурдахыг хүсэж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын төсөвт учирч болзошгүй гадаад, дотоод аливаа эрсдэлийг урьдчилан тооцож анхааруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дээрх дүгнэлтийг гаргаж Та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон бусад дагалдах хуулийн төслүүдийг хэлэлцэн батлах Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхний шийдвэр оновчтой мэргэн байх болтугай.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Би Улсын Их Хурлын гишүүдэд, бас ард иргэдэд нэг мэдээлэл өгөх нь зөв юм байна гэж үзэж байна.

Хоёр долоо хоногийн өмнө **Fitch Ratings** агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бас нэмэгдүүлсэн. 10 жилийн өмнөх үзүүлэлт дээр буюу **“В нэмэх тогтвортой”** гэсэн үзүүлэлтэд хүргэсэн байна.

Тэгвэл сая Ерөнхий сайдын үг, танилцуулга дээр гарсан хүлээгдэж байгаа хоёр дахь агентлагийн дүгнэлт дөнгөж сая гарсан талаар мэдээ ирж байна.

Тэр нь **S&P Global Ratings** агентлагаас албан ёсоор зарласан. Тэр зарласан нь бас зээлжих зэрэглэлийг ахиулж 10 жилийн өмнөх дээрээ буюу **“В нэмэх эерэг”** гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Энэ нь Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүд бас үр дүнгээ өгч байна. Засгийн газар шинээр байгуулагдаж, ирэх жилүүдэд Монгол Улсын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулсан байдал зэрэг олон талын оролцоотойгоор дүгнэлтүүд эергээр гарч байна гэж үзэж байна.

Тэгээд Засгийн газарт, Сангийн яаманд, холбогдох албан байгууллагууд, албан хаагчдад бас баяр хүргэе. Амжилт хүсье ээ, Та бүхэнд. /алга ташив/

Энэ их сайн үзүүлэлтийг одоо Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд хадгалж, дараа дараачийн орчин нөхцөлийг сайжруулах дээр бас их хичээх ёстой болж байгаа байх.

Ялангуяа 2025 оны өргөн барьж байгаа төсөв, энэ төсвийн хөрөнгө оруулалтын нөхцөл байдал дээр илүү тогтвортой байх. Магадгүй бид энэ бодлогоо тогтвортой авч явж чадвал ирэх жилүүдээс гадаад, дотоодын хөрөнгө оруулалтууд илтэд сэргэх нөхцөл үүсэх байх.

Сая төсвийн Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, аудитын байгууллагын дүгнэлт дээр ч бас энэ гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын орчин нөхцөлийг сайжруул. Хууль эрх зүйн орчин дахь томоохон шинэчлэл, тогтвортой байдлыг бий болгоход бас анхаарч ажиллах шаардлагатай гэдэг дүгнэлтүүд удаа дараа гарч байна.

Тэгэхээр олон намын оролцоотой парламент бүрдлээ. 126 гишүүнтэй ажиллана. Олон ургалч үзлээр асуудалд хандана. Хамтарсан Засгийн газар байгуулагдаж ажиллаж байна гээд зэрэг

энэ нөхцөл байдлыг давуу тал болгон энэ гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын орчин нөхцөлийг сайжруулах дээр Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд идэвхтэй ажиллах ёстой шүү гэдгийг бас Та бүхэндээ хэлэхийг хүсэж байна.

Ингээд ажлын хэсгийн гишүүдийг би танилцуулъя.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хороон дарга, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга, Болдын Жавхлан Сангийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Чинбатын Номин Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Цэндийн Баатархүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Лхагвын Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Лхагвадоржийн Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Пүрэвээгийн Дэлгэрнаран Сонгуулийн ерөнхий хорооны дарга,

Барсүрэнгийн Баасандорж Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Дэмбэрэлдашийн Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Батмөнхийн Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Гаваасүрэнгийн Азжаргал Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар, Даньхүүгийн Баянбилэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Содномцэргийн Заяадэлгэр Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Батдэмбэрэлийн Эрдэнэтулга Шүүхийн ерөнхий гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лангааны Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ядамын Самбууням Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч, Хүрэлбаатарын Мөнхзул Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Сүрэнжавын Гансэлэм Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс

баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адъяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ишжамцын Мөнхжаргал Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Болдын Отгонцэцэг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирсэн байна.

Монгол Ардын намын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар гишүүнд микрофон өгье.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга аа, улсын төсвийн тухай хуулийн холбогдох хэлэлцүүлгүүдийг ингээд үргэлжлүүлээд хийгээд яваад тодорхой шийдвэр гаргахаар Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль бас зөрчигдөж болзошгүй ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа юм.

Яагаад вэ гэхээр Улсын Их Хурал нь Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг баталсны үндсэн дээр энэ улсын төсвийг хэлэлцдэг ийм дэгтэй.

Тэгэхээр Монгол Улсын хөгжлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг хаврын чуулганаар батлах ёстой байсан.

Гэхдээ цаг хугацааны хувьд амжаагүй учраас ингээд намрын чуулган руу ингээд шилжээд ирчихсэн, дамжаад ирчихсэн.

Өчигдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлгийг нь хийлээ.

Одоо ажлын хэсэг гараад ер нь хөгжлийн төлөвлөгөө бол ингээд батлагдана.

Энэ хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлж ингэж улсын төсвийг хэлэлцэх дэгтэй байгаад байгаа юм.

Энэ бас хоёр ч хуулийн заалт бас зөрчигдөж болшгүй байгаад байгаа учраас би үүнийг хэлээд байгаа юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3-д улсын төсөв нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна гээд заачихсан.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 70.5-д болохоороо улсын төсвийн төсөл нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна гээд бүр маш тодорхой заачхаад байгаа юм.

Тийм болохоор энэ зүйлд нийцүүлэх үүднээс, хуульд нийцүүлэх үүднээс энэ Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэлэлцэж баталсны дараа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэх нь зүйтэй гэж манай бүлэг үзсэн.

Ийм болохоор Улсын Их Хурлын тухай хуулийн 31.5-д заасны дагуу ажлын 5 хоногийн завсарлага олгохыг хүсье.

Д.Амарбаясгалан: 2025 оны хөгжлийн төлөвлөгөө төсөвтэй хамт өргөн баригдсан явдал нь бас ээлжит бус чуулганы үеэр хэлэлцэхэд тодорхой зөрчлүүд хоорондоо үүсэж байна гэдэгтэй адил нөхцөл үүсэж байна гэж үзэж байна л гэж ойлгоё. Тийм ээ.

Тэгээд сонгуулийн жилтэй холбоотой, тэгээд ер нь энэ дэгийн тухай хууль, энэ хуулийн төсөл өргөн барих процесстой холбоотой зүйлүүд дээр бас ахиж нарийвчлах шаардлагууд ер нь байгаа нь харагдаж байна.

Тэгэхээр бид бас энэ дээр ч Улсын Их Хурлын зүгээс анхаараад

төсөв өргөн барих, төлөвлөгөө өргөн барих, хэлэлцүүлэн батлах гээд хоорондын зааг ялгааг нь тодорхой хугацаатай бий болгож өгөхгүй бол төлөвлөгөө, төсөв зэрэгцэж хэлэлцэгдээд байгаа нь зөрчил үүсээд байна гэдэг юм удаа дараа гарах шинжтэй болж байна. Тийм ээ.

Тэгээд яах юм. Завсарлага юм уу? 5 хоногийн.

Тэгвэл Монгол Ардын намын бүлгийн даргын саналаар 5 хоногийн завсарлага төсөв дээр өглөө. /алх цохив/

Ингээд хэлэлцэх асуудал дууссан учраас өнөөдрийн чуулган хаалаа. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 55 минут үргэлжилж, 12 цаг 58 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД